

## ГАРЧИГ

### ОРШИЛ

#### **I.ХАА-н салбарын манай улсын эдийн засагт эзлэх байр суурь**

#### **II.Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлт**

- II.1 Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
- II.2 Нэг хүнд ногдох мал аж ахуйн бүтээгдэхүүн
- II.3 Малын ашиг шим
- II.4 Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт
- II.5 Дотоодын үйлдвэрүүдэд боловсруулсан мал аж ахуйн бүтээгдэхүүн

#### **III. 2006 оны мал тооллогын дүн**

##### **III.1. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн нөхцөл**

- III.1.1 Малчдын тоо, насны бүлэг
- III.1.2. Малчдын соёл, ахуйн нөхцөл
- III.1.3 ХАА-д ажиллаж байгаа боловсон хүчин
- III.1.4 ХАА-д ашиглагдаж байгаа машин машин техникийн тоо

##### **III.2. Малын тоо, бүтэц**

- III.2.1. Малын тоо
- III.2.2. Хувийн малын тоо
- III.2.3. Хээлтэгч мал
- III.2.4. Төл бойжилт
- III.2.5. Том малын зүй бус хорогдол
- III.2.6. Малын хээл хаялт, сувайралт
- III.2.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо
- III.2.8. Малын хэрэглээний зарлага
- III.2.9. Сүргийн бүтэц

##### **IV. Эрчимжсэн мал аж ахуй**

- IV.1. Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын тоо
- IV.2. Эрчимжсэн аж ахуйн талаар

##### **V. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж**

- V.1. Бэлчээрийн хүрэлцээ
- V.2 Бэлчээр, ургамал хамгаалал
- V.3. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж

##### **VI. Тэжээвэр амьтад**

##### **VII. Мал эмнэлгийн үйлчилгээ**

##### **VIII. Малжуулалтын тайлан**

##### **IX. Худаг усан сан, усжуулалт**

- IX.1 Худаг, усан сан
- IX.2 Усжуулалтын тайлан

##### **X. Хашааны тооллого**

### ДҮГНЭЛТ

## Оршил

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн газар мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2006 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.

2006 оны хувьд мал тооллогын холбогдолтой маягт, зааварт зарчмын өөрчлөлт ороогүй бөгөөд өмнөх жилүүдэд ашиглаж байсан мал тооллогын уламжлалт 10 маягт, зааврыг мөрдлөг болгон тооллогыг явуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа. Хашаа, худаг, уст цэгийн тооллогыг 3 жил тутамд нэг удаа явуулахаар тогтсоны дагуу 2006 оны мал тооллоготой хамтруулан явуулж, үр дүнг нэгтгэсэн.

Энэхүү судалгаанд мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, тэдгээрийн экспорт, ашиг шимийн гарц болон мал эмнэлгийн арга хэмжээний талаар тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах, мөн усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хөдөөгийн хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа билээ.

Үүнтэй холбоотойгоор малжуулах болон усжуулах арга хэмжээний үр дүнг улсын хэмжээгээр нэгтгэн дүгнэх зорилгоор 2006 оны мал тооллоготой хамтруулан хоёр дахь удаагаа зохион байгуулан явууллаа.

Түүнчлэн “Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэх шаардлагыг харгалзан тус хөтөлбөрөөс малжуулалт, усжуулалтын талаархи мэдээллийг цуглуулан авч дүгнэлт хийх хүсэлт тавьсныг мөн мал тооллогын ажилтай хамтатган гүйцэтгэлээ.

Танилцуулгад улсын дүн, бүсчилсэн байдлаар Баруун, Хангай, Төв, Зүүн бүс болон Улаанбаатар гэсэн бүсүүдээр зэрэгцүүлэлт хийж харуулав.

Манай улсын мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

-----oO-----

## ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх.** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

**Малчин өрх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх

**Малчид.** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент.

**1 Адуу, үхэр- 1 бод,**

**1 тэмээ -1.5 бод,**

**6 хонь-1 бод**

**8 ямаа –1 бод**

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ-5 хонь

1 адуу- 7 хонь

1 үхэр- 6 хонь

1 хонь -1 хонь

1 ямаа- 0.9 хонь

**Нас гүйцсэн мал.** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ- 4 настай , 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

**Өсвөр насны мал .**

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

**Төл мал.** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч.** Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

**Малын тоо, толгойн өсөлт.** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана.

Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь.** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

**Бойжилтийн хувь.** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ.

**100 эхээс бойжуулсан төл.** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

**Малын зүй бус хорогдолд** өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь.** Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Малын хэрэглээний зарлага.**

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

**Малын хашааны хангамж.** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

**Тэжээл хангамж .** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

Хадлан өвс –	0.45
Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25
Гар тэжээл, хужир шүү -	1.0
Төмс ногооны хаягдал -	0.22
Үр тарианы хаягдал -	0.9
Лай -	0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал.** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
  2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Эдийн засгийн бүсэд:

**Баруун бүсийн аймгууд** – Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

**Хангайн бүс** – Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

**Төвийн бүс** - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

**Зүүн бүс** – Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг

**Улаанбаатар бүс** - Улаанбаатар хот


## I. ХАА-н салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Өнөөдөр дэлхийн хүн амын 45.0 орчим хувь нь хөдөөд амьдарч, амьдралын эх үүсвэр нь хөдөө аж ахуйн салбараас хамааралтай байгаа бөгөөд дэлхийн хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүний 5.0 орчим хувь, худалдааны эргэлтийн 7.0 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар үйлдвэрлэж бөгөөд эдгээр үзүүлэлтүүд манай орны адил хөгжиж байгаа орнуудын хувьд харьцангуй өндөр хэвээр байна.

Өнөөдрийн байдлаар манай улсын ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)-ий 20.0 орчим хувийг хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэж, хүн амын 26.1 хувь нь зөвхөн хөдөө аж ахуйг эрхлэн амьдарч байна.

Зураг 1

ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь



Дээрх графикт салбаруудыг ангилахдаа үйлдвэрлэлийн салбарт боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж, барилгын салбарыг; үйлчилгээний салбарт бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр, холбоо, төрийн удирдлага зэрэг үйлчилгээний бүх салбаруудыг хамруулав.

Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшгаас шалтгаалж энэ салбарын хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөн.

Хөдөө аж ахуйн салбар нь үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл эдлэл үйлдвэрлэл, арьс шир, хоёрдогч түүхий эд бэлтгэл, үйлчилгээний салбарын нийтийн хоолны үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

## II. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

**II.1 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт.** Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2006 онд урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 594.9 тэрбум төгрөг, зэрэгцүүлэх үнээр 314.4 тэрбум төгрөгт хүрч, 2005 онтой харьцуулахад оны үнээр 13.2 хувиар, зэрэгцүүлэх үнээр 9.7 хувиар өслөө.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь 2006 онд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 89.3 хувийг эзэлж, оны үнээр 530.9 тэрбум, зэрэгцүүлэх үнээр 280.7 тэрбум төгрөгт хүрч, 2005 онтой харьцуулахад оны үнээр 10.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 8.2 хувиар тус тус өслөө.

Мал аж ахуйн салбарт 2006 онд 355.0 мянган тонн мах, 479.4 мянган тонн сүү, 15.2 мянган тонн ноос, 4.0 мянган тонн ноолуур, 6.5 сая ширхэг арьс шир үйлдвэрлэлээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад сүү 53.6 мянган тонн, ноос 1.1 мянган тонн, ноолуур 0.3 мянган тонноор тус тус нэмэгдэж, мах 31.6 мянган тонн, арьс шир 0.4 сая ширхэгээр буурсан байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1

### Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

	2005	2006	Дүнд эзлэх хувь	
			2005	2006
<b>Мах, мян.тн</b>	<b>386.5</b>	<b>354.9</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Тэмээний	14.0	12.1	3.6	3.4
Адууний	77.0	64.2	19.9	18.1
Үхрийн	91.3	85.2	23.6	24.0
Хонины	118.1	116.9	30.6	32.9
Ямааны	85.8	76.2	22.2	21.5
Бусад	0.3	0.3	0.1	0.1
<b>Сүү, мян.тн</b>	<b>425.8</b>	<b>479.4</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Ингэний	3.7	3.8	0.9	0.8
Гүүний	41.5	43.3	9.7	9.0
Үнээний	259.5	285.7	60.9	59.6
Хонины	27.2	31.2	6.4	6.5
Ямааны	93.9	115.4	22.1	24.1
<b>Ноос, ноолуур, тн</b>	<b>19592.4</b>	<b>20974.3</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Тэмээний ноос	1002.3	969.0	5.1	4.6
Хонины ноос	14163.9	15229.5	72.3	72.6
Ямааны ноолуур	3671.4	3993.5	18.7	19.0
Ямааны ноос	157.9	127.4	0.8	0.6
Бодын хөөвөр	285.0	316.9	1.5	1.5
Бодын хялгас	311.9	338.0	1.6	1.6
<b>Арьс, мян.шир</b>	<b>6927.9</b>	<b>6488.9</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Тэмээ	35.2	31.7	0.5	0.5
Адуу	328.0	296.3	4.7	4.6
Үхэр	404.3	393.5	5.8	6.1
Хонь	3039.2	3014.5	43.9	46.5
Ямаа	2793.4	2458.5	40.3	37.9
Төлийн арьс	327.8	294.4	4.7	4.5



Үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 34.3 хувийг малын өсөлт үржилтийн бүтээгдэхүүн, 28.6 хувийг мах, 15.7 хувийг ноос, ноолуур, 13.8 хувийг сүү, 5.4 хувийг арьс, шир, 2.1 хувийг бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл тус тус эзэлж байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2

**Мал аж ахуйн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үнийн дүнгээр**

сая.төг

	Тайлант оны үнээр		2006%	2000 оны зэрэгцүүлэх үнээр		2006%
	2005	2006	2005	2005	2006	2005
Мах	221453.5	223697.2	101.0	99861.5	92469.5	92.6
Сүү	93829.4	107814.1	114.9	79899.8	90165.1	112.8
Ноос, ноолуур	102531.2	122654.5	119.6	68129.5	73981.2	108.6
Арьс, шир	42598.8	42094.0	98.8	24347.1	22627.0	92.9
Малын өсөлт, үржилтийн бүт	194147.2	268160.4	138.1	80785.7	103659.7	128.3
Бусад	15603.4	16677.0	106.9	8783.4	9067.8	103.2
<b>ДҮН</b>	<b>670163.5</b>	<b>781097.2</b>	<b>116.6</b>	<b>361807.0</b>	<b>391970.3</b>	<b>108.3</b>

2006 онд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 35.7 хувь нь ямааны аж ахуйд, 27.7 хувь нь аж ахуйд, 23.3 хувь нь үхрийн аж ахуйд, 9.8 хувь нь адууны аж ахуйд, 1.3 хувь нь тэмээний аж ахуйд тус тус ногдож байна. /Хүснэгт 3/.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нэг малд ноогдуулан тооцвол, нэг мал дунджаар 25.7 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нэг тэмээнээс 40.3 мянган төгрөг, нэг адуунаас 37.8 мянган төгрөг, нэг үхрээс 92.5 мянган төгрөг, нэг хониноос 16.8 мянган төгрөг, нэг ямаанаас 21.0 мянган төгрөгийн бүтээгдэхүүн тус тус авчээ.

Хүснэгт 3

**Мал аж ахуйн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн,  
үнийн дүнгээр, аж ахуйн төрлөөр**

	Нийт үйлдвэрлэлт, оны үнээр, сая.төг		Дүнд эзлэх хувь		1 малд ногдох, мян.төг	
	2005	2006	2005	2006	2005	2006
Тэмээний аж ахуй	9549.6	10240.6	1.4	1.3	37.2	40.3
Адууны аж ахуй	69428.1	76626.8	10.4	9.8	34.6	37.8
Үхрийн аж ахуй	153501.1	181614.3	22.9	23.3	83.4	92.5
Хонины аж ахуй	183287.7	216344.6	27.3	27.7	15.7	16.8
Ямааны аж ахуй	238276.1	279077.1	35.6	35.7	19.5	21.0
<b>Дүн</b>	<b>670163.5</b>	<b>781097.2</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>23.9</b>	<b>25.7</b>

**II.2 Нэг хүнд ногдох мал аж ахуйн бүтээгдэхүүн.** Хүн амын хүнсний хэрэглээнд зарцуулах мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүнийг тооцож үзэхэд 2006 онд нэг хүнд жилд дунджаар мах 65.9 кг, сүү 165.2 кг, өндөг 7.4 ширхэг ногдож байна.

## Нэг хүнд ногдох мал аж ахуйн бүтээгдэхүүн

	Жилд ногдох		Сард ногдох	
	2005	2006	2005	2006
Мах, нядалгааны жингээр, кг	72.6	65.9	6.0	5.5
Сүү, кг	188.2	165.2	15.7	13.8
Өндөг, шир	8.4	7.4	0.7	0.6

**II.3 Малын ашиг шим.** Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтийг үнэн зөв тооцоход нэг малын ашиг шимийн үзүүлэлт чухал байдаг. ҮСГ-аас 1998 онд малын ашиг шимийн гарцын судалгааг явуулж, гарцыг бүтээгдэхүүний төрлөөр, бүсээр тогтоосон бөгөөд уг судалгааны үр дүнг ашиглан мал аж ахуйн нийт үйлдвэрлэлтийг тооцож байна. ТАСИС-ийн “Статистик-8” төслийн хүрээнд ҮСГ 2005-2006 онд ашиг шимийн үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоох судалгааг байгалийн бүс бүрээс 2 аймаг сонгон авч, явуулж, үр дүнг гаргасан.

## Нэг малын ашиг шимийн гарц, 2006 оны түүвэр судалгаагаар

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Өндөр уулын бүс	Хангайн бүс	Тал хээрийн бүс	Говийн бүс	Улсын дундаж
<b>Малын жин, амьдын жингээр</b>						
Тэмээ	кг	436	300	358	444	<b>414</b>
Адуу	кг	240	288	237	251	<b>249</b>
Үхэр	кг	234	273	241	240	<b>247</b>
Хонь	кг	37	40	35	41	<b>41</b>
Ямаа	кг	31	36	32	32	<b>33</b>
<b>Сүүний жилийн дундаж гарц, саалинд хамрагдсан хугацаагаар</b>						
Ингэний сүү	литр	194	194	151	231	<b>194</b>
Гүүний сүү	литр	300	228	204	196	<b>198</b>
Үнээний сүү	литр	518	575	366	321	<b>497</b>
Хонины сүү	литр	10	24	38	27	<b>33</b>
Ямааны сүү	литр	14	16	15	9	<b>14</b>
<b>Ноос, ноолуурын дундаж гарц</b>						
Тэмээний ноос	грамм	3619	3333	3631	3962	<b>3812</b>
Хонины ноос	грамм	1259	1116	1258	1164	<b>1182</b>
Ямааны ноолуур	грамм	320	281	385	407	<b>301</b>
Ямааны хялгас	грамм	171	221	11	97	<b>32</b>
Адууны хөөвөр	грамм	230	214	216	181	<b>214</b>
Адууны хялгас	грамм	242	380	320	342	<b>339</b>
Үхрийн хөөвөр	грамм	156	269	320	135	<b>298</b>
Үхрийн хялгас	грамм	190	23	249	12	<b>159</b>

**II.4 Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспорт.** 2006 онд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортоос 167.6 сая ам долларын орлого олсон байна.

2006 онд бэлтгэсэн хонины ноосны 41.4 хувь буюу 6.3 мянган тонн, бэлтгэсэн ямааны ноолуурын 77.6 хувь буюу 3.1 мянган тонн бохир, угаасан болон самнасан ноолуурыг тус тус экспортод гаргасан байна. Мөн 2006 онд бэлтгэсэн нийт арьс ширний 4.5 хувь буюу 289.8 мянган ширхэг арьсийг боловсруулалт хийлгүйгээр экспортод гаргасан байна. Мөн 12.9 мянган тонн мах, 0.2 тонн сүү, цагаан идээ, 0.4 тонн өндөгний шарыг экспортод гаргасан байна.

Хүснэгт 6

**Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт**

	2005		Нэгжийн үнэ, ам.\$	2006*		Нэгжийн үнэ, ам.\$
	тоо, хэмжээ	үнийн дүн, мян.ам \$		тоо, хэмжээ	үнийн дүн, мян.ам \$	
<b>Мал амьтад, толгой</b>						
Адуу	2.0	0.5	<b>250.0</b>	18.0	9.6	<b>533.3</b>
<b>Мах, тонн</b>						
Үхрийн шинэ мах	27.3	24.5	<b>0.9</b>	194.6	309.1	<b>1.6</b>
Үхрийн хөлдүү мах	2792.4	3185.4	<b>1.1</b>	2659.8	4374.0	<b>1.6</b>
Хонь, ямааны мах	32.5	66.2	<b>2.0</b>	270.0	0.5	<b>0.0</b>
Адууны мах	4960.2	4759.9	<b>1.0</b>	8814.3	10279.4	<b>1.2</b>
Малын дайвар бүтээгдэхүүн	404.4	82.3	<b>0.2</b>	963.1	1133.6	<b>1.2</b>
<b>Сүү, цагаан идээ, кг</b>						
Хуурай сүү	128.0	0.1	<b>0.0</b>	30.0	0.7	<b>0.0</b>
Тараг, цагаан идээ	15586.5	11.8	<b>0.0</b>	164.4	2.3	<b>0.0</b>
Бяслаг, аарц	15000.0	28.4	<b>0.0</b>	42.0	0.3	<b>0.0</b>
Өндөгний шар				370.0	0.5	
<b>Ноос, ноолуур, тн</b>						
Хонины ноос	6788.9	5627.0	<b>0.8</b>	6340.1	4535.5	<b>0.7</b>
Бохир ноолуур	11.3	302.8	<b>26.8</b>	4.5	47.5	<b>10.6</b>
Угаасан ноолуур	370.0	13143.1	<b>35.5</b>	1671.2	62766.5	<b>37.6</b>
Самнасан ноолуур	919.2	52793.7	<b>57.4</b>	1388.2	79463.5	<b>57.2</b>
<b>Арьс, шир</b>						
Адууны шир	261369	4184.8	<b>16.0</b>	283153	4553.7	<b>16.1</b>
Үхрийн шир	-	-		3500	63	
Хонины арьс	2702	15.4	<b>5.7</b>	-	-	<b>-</b>
Ямаа, ишигний арьс	17200	37.6	<b>2.2</b>	3130	25.4	<b>8.1</b>

\* урьдчилсан гүйцэтгэлээр

Мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний экспортын үнийг авч үзэхэд 1 кг хонины ноосны дундаж үнэ 0.7 ам. доллар, 1 кг бохир ноолуурынх 10.6 ам доллар, 1 кг самнасан ноолуурынх 57.2 ам доллар, угаасан ноолуурынх 37.6 ам доллар, адууны ширнийх 16.1 ам доллар, ямааны арьсных 8.1 ам доллар байсан байна. Нэгж бүтээгдэхүүний экспортын үнийг 2005 оны үнэтэй харьцуулахад хонины ноос, бохир ноолуур, самнасан ноолуур, нэгжийн үнэ 0.1-16.2 ам доллараар буурч, бусад бүтээгдэхүүнийх 0.1-283.3 ам доллараар өссөн байна.

**II.5. Дотоодын үйлдвэрт боловсруулсан мал аж ахуйн бүтээгдэхүүн.** 2006 онд дотоодын үйлдвэрүүдэд, нийт үйлдвэрлэсэн сүүний 1.2 хувьтай тэнцэх 5.9 мянган тонн сүүг үйлдвэрийн аргаар боловсруулан шингэн сүү, тараг, бяслаг, аарц, цөцгий зэрэг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Мөн нийт бэлтгэсэн махны 2.8 хувьтай тэнцэх 10.0 мянган тонн махыг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрийн аргаар боловсруулалт хийж мах, хиам, консерв зэрэг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Түүнчлэн нийт үйлдвэрлэсэн ноосны 6.8 хувьтай тэнцэх 1.1 мянган тонн угаасан ноос, ноолуурын 26.7 хувьтай тэнцэх 1.1 мянган тонн самнасан ноолуур үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна.

Мөн улсын хэмжээнд бэлтгэсэн адууны ширны 2.5 хувьтай тэнцэх 7.4 мянган ширхэг, үхрийн ширны 16.5 хувьтай тэнцэх 65.1 мянган ширхэг, хонины арьсны 9.6 хувьтай тэнцэх 287.9 мянган ширхэг адуу, үхэр, хонины арьсыг тус тус дотоодын үйлдвэрт боловсруулсан байна.

Хүснэгт 7

**Дотоодын үйлдвэрт боловсруулсан малын гаралтай бүтээгдэхүүн**

	х/н	2005		нэгжийн үнэ	2006		нэгжийн үнэ
		биет хэмжээ	үнийн дүн, сая.төг		биет хэмжээ	үнийн дүн, сая.төг	
<b>Боловсруулсан мах</b>	тн	<b>5666.0</b>	<b>5932.2</b>	<b>1047</b>	<b>9980.4</b>	<b>12782.4</b>	<b>1281</b>
<b>Боловсруулсан сүү</b>	тн	<b>7803.6</b>	<b>3778.5</b>	<b>484</b>	<b>5908.4</b>	<b>3047.3</b>	<b>516</b>
<b>Ноос, ноолуур</b>							
Угаасан ноос	тн	887.4	840.4	947	1107.8	884.3	798
самнасан ноолуур	тн	581.9	29962.9	51491	1064.4	52865.1	49667
<b>Боловсруулсан арьс, шир</b>							
Адууны шир	ш	21	0.4	19048	7411.0	172.2	23240
Үхрийн шир	ш	4264	79.1	18551	65117.0	1768.9	27166
Хонины арьс	мян.ш	143.7	148.0	1030	287.9	735.6	2555

**III. Мал тооллогын дүн**

**III.1. Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд**

**III.1.1. Малтай өрх, малчдын тоо.** 2006 онд аминдаа малтай 225.3 мянган өрх, үүний дотор 170.8 мянган малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Амины малтай өрх нь улсын хэмжээний нийт өрхийн 35.6 хувийг эзэлж байна.

Малчин өрхийн ам бүлийн тоо 695.0 мянгад хүрч, нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна.

2006 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 364.4 мянган малчид ажиллаж байна. Малчдын 44.1 хувь нь буюу 160.6 мянга нь эмэгтэй малчид байна.

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 49.5 хувь нь 16-34 насны, 37.9 хувь нь 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 12.6 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

## Өрх, малчдын тоо, насны бүтэц

	2002	2003	2004	2005	2006
<b>1. Малтай өрх, (мян.)</b>	<b>243.2</b>	<b>236.2</b>	<b>229.4</b>	<b>225.4</b>	<b>225.3</b>
<b>2. Малчин өрх, (мян.)</b>	<b>175.9</b>	<b>172.4</b>	<b>169</b>	<b>168.3</b>	<b>170.8</b>
<b>3. Малчдын тоо (мян.)</b>	<b>389.8</b>	<b>377.9</b>	<b>369.7</b>	<b>364.3</b>	<b>364.4</b>
үүнээс: -16-34 насны	210.9	201.8	192.8	184.5	180.5
-35-аас тэтгэвэрт гарах хүртэлх насны	128.2	126.6	127.7	131.8	137.9
-Тэтгэврийн	50.7	49.6	49.1	48.0	45.9
<b>4. Нийт малчдаас эмэгтэй</b>	<b>165</b>	<b>161</b>	<b>158.6</b>	<b>155.5</b>	<b>160.6</b>
<b>5. Насны бүтэц %</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
үүнээс: -16-34 насны	54.1	53.4	52.2	50.6	49.5
- 35-аас тэтгэвэрт гарах хүртэлх насны	32.9	33.5	34.6	36.2	37.9
- Тэтгэврийн	13	13.1	13.3	13.2	12.6
<b>6. Нэг малчин өрхөд ногдох малын тоо</b>	<b>136</b>	<b>147</b>	<b>166</b>	<b>181</b>	<b>204</b>

2006 онд малчин өрхийн тоо 2005 онтой харьцуулахад 1.5 хувиар буюу 2.5 мянгаар өсчээ. Малчин өрхийн тоо Хөвсгөл, Төв, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Завхан, Дорнод, Булган, Баян-Өлгий, Дархан-Уул, Говь-Сүмбэр, Сүхбаатар, Хэнтий, Орхон, Увс аймаг, Улаанбаатар хотод өсч, бусад аймгуудад буурсан байна. Бүсээр авч үзвэл малчин өрхийн тоо Зүүн, Баруун, Хангайн бүс болон Улаанбаатар хотод 292-1046 өрхөөр өсч, Төвийн бүсэд 27 өрхөөр буурсан байна. Малчин өрхийн 28.9 хувь Баруун бүсэд, 40.3 хувь нь Хангайн бүсэд, 17.9 хувь нь Төвийн, 11.1 хувь нь Зүүн бүсэд, 1.7 хувь нь Улаанбаатарт тус тус ногдож байна.

2006 онд малчдын тоо 2005 оныхтой харьцуулахад улсын түвшинд ижил байна.


Аймгаар авч үзэхэд малчдын тоо Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ, Архангай, Говьсүмбэр, Сүхбаатар, Завхан, Орхон аймгуудад өнгөрсөн оныхоос 49-1262-оор нэмэгдэж, бусад аймгуудад буурав. Бүсээр авч үзвэл Баруун болон Хангай бүсэд малчдын тоо өсч, бусад бүсэд буурсан байна (Хавсралт 1, 2).

2006 онд нэг малчин өрхөд 204 толгой мал ногдож байгаа нь 2005 оныхоос 12.9 хувиар буюу 23 толгойгоор нэмэгдсэн байна. Дорноговь, Говьсүмбэр аймгуудаас бусад бүх аймагт нэг малчин өрхөд ногдох малын тоо 7-51 толгойгоор өсчээ.

Бүсээр авч үзвэл, нэг малчин өрхөд ногдох малын тоо бүх бүсэд өсөв. Баруун, Төв, Зүүн бүсийн 1 малчин өрхөд ногдох малын тоо улсын дунджаас 17-40 толгойгоор дээгүүр, Хангайн бүс, Улаанбаатарт улсын дунджаас 31-96 толгойгоор доогуур байна.

Зураг 2

Малчдын тоо, мян хүн



**III.1.2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт.** 2006 оны тооллогоор нийт малчин өрхийн 46.1 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 41.1 хувь нь телевизортой, 15.6 хувь нь авто машинтай, 24.6 хувь нь мотоцикльтой, 1.6 хувь нь трактортой, 65.4 хувь нь малын хашаатай, 17.9 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд төрөөс малчдыг цахилгаанжуулах арга хэмжээг авч явуулсны үр дүнд цахилгаан эх үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж, цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2006 онд 78.7 мянган болж, өнгөрсөн оныхоос 11.0 мянгаар буюу 16.2 хувиар нэмэгдэж, үүнийг даган, телевизортой өрхийн тоо 10.1 мянгаар буюу 16.8 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн автомашинтай өрхийн тоо 2005 оныхоос 3.4 мянгаар буюу 14.7 хувиар, мотоцикльтэй өрхийн тоо 4.2 мянгаар буюу 11.1 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 9


**Малчин өрхийн соёл ахуйн үзүүлэлтүүд**

	Өрхийн тоо, мян.					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2002	2003	2004	2005	2006	2002	2003	2004	2005	2006
Цахилгаан үүсгүүртэй	24.1	28.9	53.7	67.7	78.7	13.7	16.7	31.8	40.2	46.1
Телевизортой	29.4	33.2	48.6	60.1	70.2	16.7	19.3	28.7	35.7	41.1
Автомашинтай	18.4	19.8	21.8	23.2	26.6	10.5	11.5	12.9	13.8	15.6
Мотоцикльтэй	32.6	33.4	35.7	37.8	42.0	18.6	19.4	21.1	22.2	24.6
Трактортой	2.7	2.7	2.6	2.4	2.7	1.5	1.5	1.5	1.4	1.6

Аймаг, бүсээр харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-аас харна уу.

Зураг 3

**Малчин өрхийн соёл ахуйн үзүүлэлтүүд, мян.өрх**



2005 онд малчин өрхийн 40.2 хувь нь цахилгаан үүсгүүртэй байсан бол 2006 онд 46.1 хувь болж, 5.9 пунктээр нэмэгдсэн байна. Цахилгаан үүсгүүрээс аль төрөл нь малчин өрхийн гол хэрэглээ болж байгааг тодорхойлох зорилгоор 2006 оны мал тооллогоор цахилгаан үүсгүүрийг төрлөөр задлан авсан.

## Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо

	Бүгд	Үүнээс				Дүнд эзлэх хувь			
		Нарны	Салхины	Бага оврын мотор	Бусад	Нарны	Салхины	Бага оврын мотор	Бусад
Цахилгаан үүсгүүртэй өрх	78711	62053	7101	3287	6270	78.8	9	4.2	8

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 78.8 хувь нь нарны, 9.0 хувь нь салхины, 4.2 хувь нь бага оврын мотор /хонда, ямаха/, 8.0 хувь нь бусад /нар, салхины хосолсон, аккумулятор / төрлийн цахилгаан эх үүсгүүртэй гэсэн дүнтэй байна.

**III.1.3 ХАА-д ажиллаж байгаа боловсон хүчин.** 2006 оны байдлаар ХАА-н үйлдвэрлэлд 1838 малын эмч, 821 мал зүйч, 534 агрономич, 2411 механикжуулагч ажиллаж байна. /Хавсралт 55/

Хүснэгт 3

## Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд байгаа боловсон хүчин

	1996	2000	2003	2006	2006/2003	
					%	Зөрүү
Мал зүйч	421	1134	892	821	92.0	-71
Малын эмч	1539	2032	2009	1838	91.5	-171
Агрономич	236	477	465	534	114.8	69
Механикжуулагч	6146	4263	3695	2411	65.3	-1284

**III.1.4 ХАА-д ажиллаж байгаа боловсон хүчин, ашиглагдаж байгаа машин техникийн тоо.** 2006 оны байдлаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 3.9 мянган трактор, 0.6 мянган үр тарианы комбайн, 1.0 мянган тариа, ногоо үрлэгч, 0.2 мянган төмс суулгагч ашиглагдаж байна. /Хавсралт 56/

Хүснэгт 11

## Хөдөө аж ахуйд ашиглагдаж байгаа гол төрлийн техникийн тоо

	1996	2000	2003	2006	2006/2003	
					%	Зөрүү
Трактор	7011	4733	4193	3891	92.8	-302
Үр тарианы комбайн	1373	1086	1072	617	57.6	-455
Тариа үрлэгч	2881	1995	1585	934	58.9	-651
Ногоо үрлэгч	78	61	191	73	38.2	-118
Төмс суулгагч	180	167	170	236	138.8	66

### III.2. Мал, тэжээвэр амьтдын тоо, бүтэц

**III.2.1. Малын тоо.** 2006 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 34.8 сая толгойд хүрч, 2005 оныхоос 4.4 саяар буюу 14.5 хувиар өслөө. Тооллогын дүнгээр тэмээний тоо 253.5 мянга, адуу 2114.8 мянга, үхэр 2167.9 мянга, хонь 14815.1 мянга, ямаа 15451.7 мянгад хүрч, 2005 оныхоос адуу 85.7 мянга, үхэр 204.3 мянга, хонь 1930.6 мянга, ямаа 2184.3 мянган толгойгоор тус тус өсч, харин тэмээний тоо 0.7 мянгаар буурлаа (Хавсралт 7, 8).

Мал тооллогын 2006 оны дүнгээр 536.5 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 24.7 хувийг эзэлж байна (Хавсралт 39). Сарлагийн тоо 2005 оныхоос 11.5 хувь буюу 55.3 мянган толгойгоор өссөн байна.

Хүснэгт 12

#### Малын тоо, төрлөөр

МЯН.ТОЛ

	2002	2003	2004	2005	2006	2006/2005	
						%	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>23 897.6</b>	<b>25 427.7</b>	<b>28 027.9</b>	<b>30398.8</b>	<b>34802.9</b>	<b>114.5</b>	<b>4404.1</b>
Тэмээ	253.0	256.7	256.6	254.2	253.5	99.7	-0.7
Адуу	1 988.9	1 968.9	2 005.3	2029.1	2114.8	104.2	85.7
Үхэр	1 884.3	1 792.8	1 841.6	1963.6	2167.9	110.4	204.3
Хонь	10 636.6	10 756.4	11 686.4	12884.5	14815.1	115.0	1930.6
Ямаа	9 134.8	10 652.9	12 238.0	13267.4	15451.7	116.5	2184.3

Малын тоо толгойн өсөлт нь бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 49.6 хувийг ямаа, 43.8 хувийг хонь, 4.6 хувийг үхэр, 1.9 хувийг адуу хангасан байна.


Энэхүү өсөлтөд 2006 онд болон сүүлийн 3 жил дараалан цаг агаарын байдал өмнөх жилүүдтэй харьцуулахад тааламжтай байж, 2005 онтой харьцуулахад малын хорогдол 200.8 мянгаар буурч, бойжуулсан төлийн тоо 1445.6 мянгаар нэмэгдснээс, малын тоо 4.4 сая толгойгоор өссөн нь голлон нөлөөллөө.

Мал тооллогын дүнгээр нийт 21 аймаг буюу Дорноговь аймгаас бусад бүх аймгууд малаа 2005 онтой харьцуулахад 3.1-30.3 хувиар буюу 14.4-469.2 мянган толгойгоор өсгөжээ. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр зэрэг 12 аймаг, Улаанбаатар хот мал сүргээ нийт толгойн тоогоор таван төрөл дээр нь өсгөсөн байна. Харин Дорноговь аймагт малын тоо, толгой нийт дүнгээрээ өмнөх оныхоос 26.6 хувиар буюу 258.7 мянган толгойгоор буурчээ. Дорноговь аймагт зуншлага муу байснаас малын хээл хаялт, сувайралт ихэсч, бойжуулсан төлийн тоо өмнөх онтой харьцуулахад 156.7 мянган толгойгоор буурсан нь малын тоо буурахад голлон нөлөөлжээ.



## Малын тоо

МЯН.ТОЛ



Нийт малын 31.4 хувь буюу 10914.8 мянга нь Баруун бүсэд, 34.1 хувь буюу 11852.7 мянга нь Хангай бүсэд, 20.3 хувь буюу 7071.2 мянга нь Төвийн бүсэд, 13.3 хувь буюу 4642.1 мянга нь Зүүн бүсэд, 0.9 хувь буюу 321.9 мянга нь Улаанбаатар хотод тус тус ногдож байна (Хавсралт 8).

Хүснэгт 13

## Малын тоо, бүс нутгаар

МЯН.ТОЛ


Бүс	2001	2002	2003	2004	2005	2006	2006/2005	
							%	Зөрүү
<b>Дүн</b>	<b>26 075.2</b>	<b>23 897.6</b>	<b>25 427.8</b>	<b>28 028.1</b>	<b>30398.8</b>	<b>34802.9</b>	<b>114.5</b>	<b>4404.1</b>
Баруун	7 587.2	6 482.2	7 410.8	8 524.8	9242.1	10915.0	118.1	1672.7
Хангай	8 683.3	7 724.6	8 131.8	9 050.9	10090.3	11852.6	117.5	1762.4
Төв	6 003.4	5 737.3	5 723.7	6 252.8	6628.2	7071.2	106.7	443.0
Зүүн	3 579.9	3 720.0	3 918.2	3 973.2	4191.3	4642.1	110.8	450.8
УБ	221.4	233.5	243.3	226.4	247.0	322.0	130.3	74.9

2006 онд тоологдсон малын тоог 2005 онтой харьцуулахад Баруун бүсийн малын тоо 1672.7 мянга буюу 18.1 хувиар, Хангайн бүсийнх 1762.4 мянга буюу 17.5 хувиар, Төвийн бүсийнх 6.7 хувь буюу 443.0 мянгаар, Зүүн бүсийнх 450.8 мянга буюу 10.8 хувиар, Улаанбаатарынх 74.9 мянга буюу 30.3 хувиар тус тус өсчээ. Баруун болон Хангайн бүс, Улаанбаатарын малын тоо 5 төрөл дээрээ өсөв. Нийт малын өсөлтийн 40.0 хувь нь Хангайн бүсийн, 38.0 хувийг Баруун бүсийн, 10.2 хувь нь Зүүн бүсийн, 10.1 хувь нь Төвийн бүсийнх, 1.7 хувь нь Улаанбаатарын малын тооны өсөлтөөр хангагдсан байна.

Зураг 5

**Малын тоо, бүс нутгаар**

МЯН.ТОЛ



Таван төрлийн малын тооны өсөлт, бууралтыг 2005 онтой харьцуулан аймгаар авч үзэхэд тэмээ 13 аймаг, Улаанбаатар хотод, адуу 17 аймагт, Улаанбаатар хотод, үхэр 19 аймаг, Улаанбаатар хотод, хонь, ямаа 20 аймаг, Улаанбаатар хотод тус тус өссөн байна.

2006 оны байдлаар нийт мал сүргийн 87.0 хувийг бог мал, 13.0 хувийг бод мал эзэлж байна. Бүсээр авч үзэхэд Баруун бүсийн нийт малын 8.7 хувийг бод, 91.3 хувийг бог, Хангайн бүсийн нийт малын 14.3 хувийг бод, 85.7 хувийг бог, Төвийн бүсийн малын 12.8 хувийг бод, 87.2 хувийг бог, Зүүн бүсийн малын 19.6 хувийг бод, 80.4 хувийг бог, Улаанбаатарын малын 23.2 хувийг бод, 76.8 хувийг бог мал эзэлж байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ 0.7, адуу 6.1 үхэр 6.2, хонь 42.6, ямаа 44.4 хувийг эзэлж байна. 2006 онд нийт мал сүрэгт хонь, ямаан сүргийн эзлэх хувийн жин 0.2-0.8 пунктээр өсч, бусад төрлийн малын эзлэх хувийн жин 0.1-0.6 пунктээр буурчээ.

Хүснэгт 14


**Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь**

	2002	2003	2004	2005	2006
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	1.1	1	0.9	0.8	0.7
Адуу	8.3	7.7	7.2	6.7	6.1
Үхэр	7.9	7.1	6.6	6.5	6.2
Хонь	44.5	42.3	41.7	42.4	42.6
Ямаа	38.2	41.9	43.7	43.6	44.4

2006 оны байдлаар авч үзэхэд бог малын 48.9 хувийг хонь, 51.1 хувийг ямаа эзэлж байна .

Зураг 6

### Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь




2006 онд, улсад, нийт мал болон үхрээр Хөвсгөл, тэмээгээр Өмнөговь, адуугаар Архангай, хониор Завхан, ямаагаар Говь-Алтай аймаг тэргүүлж байна (Хавсралт 6).

Бүсээр авч үзвэл нийт мал болон адуу, үхэр, хониор Хангайн бүс, ямаагаар Баруун бүс, тэмээгээр Төвийн бүс тэргүүлж байна.

Зураг 7

### 2006 оны малын тоо, аймагаар



**III.2.2 Хувийн малын тоо.** 2006 онд хувийн малын тоо 34.3 сая толгойд хүрч, нийт малын 98.6 хувийг эзэлж байна. Тэмээний 98.5 хувь, адууны 98.8, үхрийн 98.8, хонины 98.0 ямааны 99.1 хувь нь хувийн аж ахуйд байна (Хавсралт 10,11, 13). Хувийн малын тоо 2005 оныхоос 4413.2 мянгаар буюу 114.8 хувиар өслөө.

## Хувийн малтай өрх, малын тоо

МЯН.ТОЛ

	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	262.3	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	278.3	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	279.7	29529.0	343.8	2807.4	3485.4	12912.0	9980.5
1998	275.0	31356.3	346.4	2982.6	3613.5	13630.1	10783.8
1999	270.0	32278.7	346.4	3097.3	3733.2	14306.5	10795.3
2000	268.7	29236.7	315.5	2609.4	3028.3	13206.0	10077.5
2001	256.6	25335.6	278.3	2152.4	2031.8	11439.0	9434.2
2002	243.2	23280.0	247.2	1953.0	1853.4	10232.4	8994.1
2003	236.2	24888.8	251.8	1937.5	1768.3	10417.6	10513.5
2004	229.4	27517.5	252.1	1973.4	1817.0	11376.9	12098.1
2005	225.4	29901.8	250.0	2001.2	1940.3	12582.9	13127.4
2006	225.4	34315.0	249.7	2088.7	2142.3	14522.1	15312.2

2006 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 44.6 хувийг ямаа, 42.3 хувийг хонь, 6.1 хувийг адуу, 6.2 хувийг үхэр, 0.7 хувийг тэмээ эзэлж байна.

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 2006 онд 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 117.4 болж, 2005 оныхоос 12.2 мянган өрхөөр буюу 9.4 хувиар буурч, 100 дээш малтай өрхийн тоо 108.0 мянгад хүрч 2005 оныхоос 12.2 мянга буюу 12.7 хувиар өслөө.

2006 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 52.1 хувь болж, 2005 оныхоос 5.4 пунктээр буурч, харин түүнээс дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 47.9 хувь болж, 5.4 пунктээр нэмэгдсэн байна.

2006 оны байдлаар малтай өрхийн 75.3 хувь нь 200 хүртэл толгой малтай байна. Уг үзүүлэлт 2005 онд 79.4 хувьтай байсан бөгөөд 4.2 пунктээр багассан байна. Амьдрал дээр 200 хүртэл толгой малтай өрх өрхийн хэрэгцээгээ хангахад хүрэлцээтэй бус гэж малчид үзэж байна.

**Малтай өрхийн малын бүлэглэлт**

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо, мян.тол	
	2005	2006	2005	2006	2005	2006
<b>Дүн</b>	<b>225393</b>	<b>225366</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>29901.8</b>	<b>34315.0</b>
100 хүртэл малтай	129553	117363	57.5	52.1	5310.7	4944.5
101-200 малтай	49498	52445	22.0	23.2	7094.5	7593.8
201-500 малтай	38245	44765	17.0	19.8	11366.7	13365.0
501-999 малтай	6527	8458	2.8	3.8	4184.9	5486.7
1000-1499 малтай	1354	2024	0.6	0.9	1531	2307.5
1500-2000 малтай	142	182	0.1	0.1	238.8	305.5
2001-ээс дээш малтай	74	129	0.0	0.1	175.2	312.1

Аймгаар авч үзэхэд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 2005 онд 61.3-97.1 хувьтай байсан бол 2006 онд 59.1-95.6 хувь болсон байна. Бүсээр авч үзвэл 2006 онд 200 хүртэл толгой малтай өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувь Баруун бүсэд 72.7 Хангай бүсэд 77.9, Төвийн бүсэд 73.5 хувь, Зүүн бүсэд 72.1 хувь, Улаанбаатарт 95.6 хувь болж, 2005 оныхоос 1.5-5.3 пунктээр буурсан байна.

2006 онд 1000 ба түүнээс дээш малтай 2335 өрх тоологдож, 2005 оныхоос 765 өрхөөр нэмэгдсэн байна. 1000-аас дээш малтай өрхийн 34.0 хувь нь Баруун бүсэд, 25.9 хувь нь Хангайн бүсэд, 21.5 хувь нь Зүүн бүсэд, 18.0 хувь нь Төвийн бүсэд ногдож байна.

1000-аас дээш малтай өрхийн тоогоор Завхан аймаг тэргүүлж байна. (Хавсралт 5)

**Малтай нэг өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр**

	2004	2005	2006	Үүнээс:				
				тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
<b>Дүн</b>	<b>121</b>	<b>133</b>	<b>152</b>	<b>1</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>64</b>	<b>68</b>
10 хүртэл малтай	6	6	6	0	1	3	1	1
11-30 малтай	21	20	21	0	2	5	5	9
31-50 малтай	40	41	41	0	3	6	12	20
51-100 малтай	74	75	75	0	5	7	25	37
101-200 малтай	141	144	145	1	9	10	54	71
201-500 малтай	296	297	299	2	17	15	129	136
501-999 малтай	638	641	649	4	37	28	324	255
1000-1499 малтай	1132	1131	1140	6	63	47	637	387
1500-2000 малтай	1680	1681	1679	11	102	69	994	503
2001-ээс дээш малтай	2278	2366	2420	11	170	113	1405	720

Улсын дунджаар хувийн малтай нэг өрхөд 152 толгой мал ногдож байгаа нь 2005 оныхоос 19 толгой малаар илүү байна. Малтай нэг өрхөд тэмээ 1, адуу 9, үхэр 10, хонь 64, ямаа 68 ногдож байна.

1 өрхөд ногдох малын бүтцийг авч үзэхэд 86.8 хувь нь бог мал, 13.2 хувь нь бод мал байна.

200 хүртэл толгой малтай нэг өрхөд дунжаар 119 толгой, 201-999 малтай нэг өрхөд 354 толгой, 1000 ба түүнээс дээш малтай өрхөд 1253 толгой мал тус тус ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо (толгойгоор) Дорноговь аймгаас бусад бүх аймгуудад 2005 оныхоос 9-33 толгойгоор нэмэгдсэн байна.

Бүсээр авч үзэхэд 2006 онд малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо бүх бүсэд 2005 оныхоос 10-24 толгойгоор нэмэгдсэн байна. Зүүн, Баруун болон Төвийн бүсийн малтай нэг өрхөд ногдох мал улсын дунджаас 2-24 толгойгоор дээгүүр байна (Хавсралт 12).

**III.2.3 Хээлтэгч мал.** 2006 оны эцэст 14712.4 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь 2005 оныхоос 1828.7 мянган толгой буюу 14.2 хувиар өссөн байна.

Төрлөөр авч үзвэл хээлтэгч малын тоо бүх төрөл дээр өссөн бөгөөд ингэ 0.5 мянга, гүү 24.3 мянга, үнээ 75.1 мянга, эм хонь 859.7 мянга, эм ямаа 868.9 мянган толгойгоор тус тус өссөн байна. (Хавсралт 24).

Хүснэгт 18

### Хээлтэгч малын тоо


МЯН.ТОЛ

	2002	2003	2004	2005	2006	2006/2005	
						%	Зөрүү
<b>Бүгд</b>	<b>10479.1</b>	<b>10804.8</b>	<b>11604.7</b>	<b>12883.7</b>	<b>14712.4</b>	<b>114.2</b>	<b>1828.7</b>
Тэмээ	75.2	77.7	77.4	76.3	76.8	100.7	0.5
Адуу	594.7	580.2	571.8	569.7	594.0	104.3	24.3
Үхэр	773.8	721.4	733.3	764.3	839.4	109.8	75.1
Хонь	4861.4	4853.2	5147.5	5751.8	6611.5	114.9	859.7
Ямаа	4174.1	4572.4	5074.8	5721.8	6590.7	115.2	868.9

Хээлтэгч мал нийт малын 42.3 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.2 хувь, адуун сүргийн 28.1 хувь, үхэр сүргийн 38.7 хувь, хонин сүргийн 44.6 хувь, ямаан сүргийн 42.7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 8

### Хээлтэгч малын тоо



Аймгаар авч үзвэл хээлтэгч малын тоо нь Дорноговь аймагт 66.8 мянган толгой буюу 16.4 хувиар буурч, бусад аймгуудад 9.3-198.7 мянган толгойгоор буюу 8.0-28.8 хувиар нэмэгджээ (Хавсралт 25).

Бүсээр авч бүх бүсэд хээлтэгч малын тоо 8.9-28.8 хувь буюу 33.5-722.1 мянган толгойгоор өссөн байна. Төвийн болон Зүүн бүсийн нийт малын 43.8 хувь, Хангайн бүсийн нийт малын 41.5 хувь, Баруун бүсийн нийт малын 41.4 хувь, Улаанбаатар хотын нийт малын 46.5 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

**III.2.4 Төл бойжилт.** 2006 онд гарсан төлийн 95.3 хувийг буюу 10778.6 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2005 оныхоос 1445.6 мянган толгойгоор нэмэгдэж, бойжилтын хувь 1.2 пунктээр өссөн байна.

Гарсан ботгоны 93.8 хувь, унаганы 92.6 хувь, тугалны 96.3 хувь, хурганы 96.2, ишигний 94.5 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төлийг 2005 онтой харьцуулан төрлөөр нь авч үзвэл ботго 1.3 мянган толгойгоор буурч, унага, тугал хурга, ишиг 6.7-761.6 мянган толгойгоор нэмэгджээ.

Хүснэгт 19

### Төл бойжилт


МЯН.ТОЛ

	Бүгд			үүнээс				
	2004	2005	2006	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	9562.8	9913.7	<b>11309.0</b>	35.5	425.4	635.2	5207.2	5005.6
Бойжсон төл	9296.1	9333.0	<b>10778.6</b>	33.3	394.1	611.6	5009.1	4730.5
Бойжилтийн хувь	97.2	94.1	<b>95.3</b>	93.8	92.6	96.3	96.2	94.5

2006 онд бойжуулсан төлийн Увс, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл, Говь-Алтай, Төв, Ховд, Баян-Өлгий, Архангай, Булган, Баянхонгор, Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Сүхбаатар, Дундговь, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймаг, Улаанбаатар хотод 4.9-216.2 мянган толгойгоор өсч, харин Өмнөговь, Дорноговь аймагт 22.0-156.7 мянган толгойгоор буурсан байна (Хавсралт 27).

Зураг 9

### Бойжуулсан төлийн тоо



Бойжуулсан төлийг бүсээр авч үзвэл, бүх бүсэд бойжуулсан төлийн тоо 10.8-745.1 мянган толгойгоор нэмэгджээ.

Нийт бойжуулсан төлийн 33.0 хувь нь Баруун бүсэд, 33.8 хувь нь Хангайн бүсэд, 18.7 хувь нь Төвийн бүсэд, 13.6 хувь нь Зүүн бүсэд, 0.9 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Хүснэгт 20

### Бойжуулсан төл


МЯН.ТОЛ

	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>7370.7</b>	<b>6808.7</b>	<b>7885.5</b>	<b>9296.1</b>	<b>9333</b>	<b>10778.6</b>
Ботго	28.2	25.1	31.7	35.8	34.6	33.3
Унага	308.8	318	306.3	384.1	387.4	394.1
Тугал	539.4	513.5	512.8	549	569.3	611.6
Хурга	3967	3612.5	3761	4250.4	4372.8	5009.1
Ишиг	2527.4	2339.6	3273.7	4076.8	3968.9	4730.5

Улсын дунджаар 100 эхээс 84 төл бойжуулсан байна. 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2005 оныхоос 4 төлөөр нэмэгдэв. Баян-Өлгий, Увс, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Өвөрхангай, Төв, Ховд, Хөвсгөл, Дорнод, Булган, Дархан-Уул, Архангай аймгуудад 100 эхээс бойжуулсан төлийн тоо 1-17 толгойгоор нэмэгдэж, бусад аймагт 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2-38 толгойгоор буурсан байна. (Хавсралт 28).

Зураг 10

### 100 эхээс бойжуулсан төл



Бүсээр авч үзвэл, Баруун, Хангай, Зүүн бүс болон Улаанбаатар хотод 100 эхээс бойжуулсан төлийн тоо 2005 оныхоос 3-10 толгойгоор өсч, харин Төвийн бүсэд 6 толгойгоор буурсан байна.

Улсын дундажтай харьцуулахад Баруун, Хангайн бүс, Улаанбаатар хотод 100 эхээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас 1-7 төлөөр дээгүүр, Төвийн болон Зүүн бүсэд 3-13 төлөөр доогуур байна.



## 100 эхээс бойжуулсан төл

	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>60</b>	<b>75</b>	<b>86</b>	<b>80</b>	<b>84</b>
Ботго	30	42	46	45	44
Унага	46	52	66	68	69
Тугал	60	66	76	78	80
Хурга	66	77	88	85	87
Ишиг	54	78	89	78	83

**III.2.5 Том малын зүй бус хорогдол.** 2006 онд, оны эхний нийт малын 1.6 хувьтай тэнцэх 476.4 мянган толгой мал хорогдсон нь 2005 оныхоос 200.8 мянгаар буюу 29.7 хувиар буурсан байна. Нийт хорогдсон малын 46.0 хувийг ямаа, 38.2 хувийг хонь, 8.3 хувийг үхэр, 6.4 хувийг адуу, 1.0 хувийг тэмээ эзэлж байна.

Хүснэгт 22

## Том малын зүй бус хорогдол


мян.тол

	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>4758.9</b>	<b>2917.6</b>	<b>1324.3</b>	<b>291.7</b>	<b>677.2</b>	<b>476.4</b>
Тэмээ	20.5	25.7	7.3	2.4	3.7	4.7
Адуу	449.8	213.4	136.7	31	39.1	30.6
Үхэр	1018.5	196.4	215.4	46	58.1	39.5
Хонь	1988.2	1174	536.6	116	255.7	182.2
Ямаа	1282	1308.1	428.4	96.3	320.7	219.3

Том малын зүй бус хорогдол Дорноговь, Дундговь, Хэнтий, Өмнөговь, Баянхонгор, Архангай, Говьсүмбэр аймгууд, Улаанбаатар хотод 2005 оныхоос 0.4-100.3 мянган толгойгоор нэмэгдэж, бусад аймагт 0.2-78.5 мянган толгойгоор буурсан байна. (Хавсралт 29).

Зураг 11

## Том малын зүй бус хорогдол



Бүсээр авч үзвэл, Төвийн бүсээс бусад бүх бүсэд хорогдлын хэмжээ 0.6-235.1 мянган толгойгоор буурсан. Нийт хорогдлын 50.5 хувь нь Төвийн бүсэд, 18.4 хувь нь Хангайн бүсэд, 15.4 хувь нь Баруун бүсэд, 15.2 хувь нь Зүүн бүсэд гарсан байна.

Хүснэгт 23

#### Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>11.2</b>	<b>5.5</b>	<b>1.1</b>	<b>2.4</b>	<b>1.6</b>
Тэмээ	9.0	2.9	1.0	1.4	1.9
Адуу	9.7	6.9	1.6	1.9	1.5
Үхэр	9.5	11.4	2.6	3.2	2.0
Хонь	9.8	5.0	1.1	2.2	1.4
Ямаа	13.6	4.7	0.9	2.6	1.7

2006 онд 73.0 мянган мал гэнэтийн аюулаар хорогдсон нь 2005 оныхоос 50.5 мянган толгойгоор буюу 40.9 хувиар буурсан байна. (Хавсралт 30).

Нийт хорогдлын 15.3 хувь буюу 73.0 мянга нь гэнэтийн аюулаар, 84.7 хувь буюу 403.4 мянга нь өвчнөөр болон бусад шалтгаанаар хорогджээ.

Хүснэгт 24

#### Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

МЯН.ТОЛ

	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>2694</b>	<b>1630.2</b>	<b>643.3</b>	<b>39.6</b>	<b>123.5</b>	<b>73.0</b>
Тэмээ	6.3	12.4	1.1	0.2	0.4	0.5
Адуу	261.1	97.9	65.9	3.4	5.1	5.0
Үхэр	585.9	82.9	107.6	4.6	10.4	5.2
Хонь	1158.5	655.9	267.9	17.3	48.6	29.1
Ямаа	682.2	781.1	200.9	14.2	59.1	33.3

Гэнэтийн аюулаар хорогдсон малын 29.1 хувь нь Дорноговь аймагт, 14.8 хувь нь Хэнтий аймагт, 13.9 хувь нь Увс аймагт гарсан байна.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын 44.3 хувь нь Төвийн бүсэд, 24.7 хувь нь Зүүн бүсэд, 19.8 хувь нь Баруун бүсэд, 10.1 хувь нь Хангайн бүсэд тус тус ногдож байна.

**III.2.6. Малын хээл хаялт, сувайралт.** Оны эхний хээлтэгч малын 9.6 хувьтай тэнцэх 1.2 сая мал 2006 онд хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо 2005 оныхоос 7.6 хувь буюу 101.7 мянгаар буурчээ.

Төл өгөөгүй хээлтэгч малын 73.0 хувь буюу 898.9 мянга нь сувайрсан хээлтэгч, 27.0 хувь буюу 332.9 мянга нь хээл хаясан эх мал байна.

**Хээл хаяж, сувайрсан эх малын тоо**

МЯН.ТОЛ

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2004	2005	2006	2004	2005	2006	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>951.8</b>	<b>1333.5</b>	<b>1231.8</b>	<b>700.1</b>	<b>820.7</b>	<b>898.9</b>	<b>251.8</b>	<b>512.9</b>	<b>332.9</b>
Ингэ	3.4	3.6	3.4	2.9	3.1	2.9	0.5	0.6	0.5
Гүү	128.9	112.2	110.0	99.3	85.8	85.2	29.7	26.4	24.8
Үнээ	119.3	109.2	105.3	93.7	82.8	84.9	25.6	26.4	20.5
Эм хонь	351.5	416.2	412.6	260.7	310.4	314.1	90.8	105.8	98.5
Эм ямаа	348.7	692.3	600.5	243.5	338.7	411.8	105.2	353.6	188.7

Аймгаар авч үзвэл, Баян-Өлгий, Увс, Завхан, Ховд, Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод, Сүхбаатар, Архангай, Төв, Булган, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотод төл өгөөгүй хээлтэгч малын тоо 0.1-67.4 мянган толгойгоор буурч, бусад аймгуудад 1.2-66.8 мянгаар нэмэгджээ. (Хавсралт 31, 32, 33).

Хүснэгт 26

**Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь**

	Төл өгөөгүй хээлтэгч			Сувайрсан			Хээл хаясан		
	2004	2005	2006	2004	2005	2006	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>8.8</b>	<b>11.5</b>	<b>9.6</b>	<b>6.5</b>	<b>7.1</b>	<b>7.0</b>	<b>2.3</b>	<b>4.4</b>	<b>2.6</b>
Ингэ	4.4	4.7	4.5	3.7	4.0	3.8	0.6	0.7	0.6
Гүү	22.2	19.6	19.3	17.1	15.0	15.0	5.1	4.6	4.3
Үнээ	16.5	14.9	13.8	13	11.3	11.1	3.6	3.6	2.7
Эм хонь	7.2	8.1	7.2	5.4	6.0	5.5	1.9	2.1	1.7
Эм ямаа	7.6	13.6	10.5	5.3	6.7	7.2	2.3	7.0	3.3

Хээл хаяж, сувайрсан эх малын 16.2 хувь нь Баруун, 28.4 хувь нь Хангайн, 38.6 хувь нь Төвийн, 15.7 хувь нь Зүүн бүсэд, 1.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

**III.2.7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.** Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

2006 онд 338.0 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2005 оныхоос 28.8 мянган толгойгоор буюу 9.3 хувиар өсчээ.

Хүснэгт 27

**Хээлтүүлэгч малын тоо**

МЯН.ТОЛ

	Хээлтүүлэгч мал-бүгд					Үүнээс: шинээр тавьсан				
	2002	2003	2004	2005	2006	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>276</b>	<b>295.9</b>	<b>296.1</b>	<b>309.2</b>	<b>338.0</b>	<b>13.5</b>	<b>12.2</b>	<b>7.6</b>	<b>8.7</b>	<b>10.1</b>
Буур	3.7	3.8	3.5	3.3	3.3	0.1	0.1	0.1	0.0	0.0
Азарга	91.2	89.5	85.8	83.5	83.7	1.2	1.0	0.7	0.7	0.6
Бух	26.9	26.5	26	27.7	31.0	1.3	1.0	0.6	0.7	0.8
Хуц	82.8	91	91.3	101.2	110.8	5.8	5.3	3.3	3.9	4.4
Ухна	71.4	85.1	89.5	93.5	109.2	5.1	4.8	2.9	3.4	4.3

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 2006 онд улсын дунджаар 60 эм хонь, ямаа ногдож, 2 дахин өндөр үзүүлэлт гарч байна (Хавсралт 32).

Хүснэгт 28

### Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

	Үржлийн норм	2002	2003	2004	2005	2006
Ингэ	20-25	21	21	22	23	24
Гүү	12-15	7	7	7	7	7
Үнээ	35-45	29	27	28	28	27
Эм хонь	25-30	59	53	53	57	60
Эм ямаа	25-30	59	54	51	61	60

**III.2.8. Малын хэрэглээний зарлага.** 2006 онд оны эхний нийт малын 19.4 хувьтай тэнцэх 5898.0 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2005 оныхоос 386.0 мянган толгойгоор буурав (Хавсралт 38).

Малтай нэг өрх дунджаар 26 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна.

Үүнийг улсын хэмжээний нийт өрхөд оногдуулбал нэг өрх дунджаар 9.3 толгой мал буюу 2.6 бодыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хүснэгт 29

### Малын хэрэглээний зарлага

мян.тол

	2002	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>6076.1</b>	<b>5034.5</b>	<b>6404.9</b>	<b>6284.0</b>	<b>5898.0</b>
Тэмээ	31.8	20.7	33.3	33.4	29.6
Адуу	314.2	193.6	317.6	324.5	277.8
Үхэр	502.5	388.7	454.2	389.2	367.6
Хонь	3739.6	3104.4	3204.3	2918.2	2896.0
Ямаа	1488	1327.1	2395.5	2618.8	2326.9
Оны эхний малд эзлэх хувь					
<b>Бүгд</b>	<b>23.3</b>	<b>21.1</b>	<b>25.2</b>	<b>22.4</b>	<b>19.4</b>
Тэмээ	11.1	8.2	13.0	13.0	11.5
Адуу	14.3	9.7	16.1	16.2	13.7
Үхэр	24.3	20.6	25.3	21.1	18.7
Хонь	31.3	29.2	29.8	25.0	22.5
Ямаа	15.5	14.5	22.5	21.4	17.5

Хэрэглээнд зарцуулсан малын 88.6 хувийг бог мал, 11.4 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхний тэмээний 11.5 хувь, адууны 13.7 хувь, үхрийн 18.7 хувь, хонины 22.5 хувь, ямааны 17.5 хувийг хэрэглээнд зарцуулсан байна.

**Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо**

МЯН.ТОЛ

	Зах зээлд худалдан борлуулсан				Аж ахуйн дотоодод хэрэглэсэн			
	2003	2004	2005	2006	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>1828.3</b>	<b>2230.2</b>	<b>2317.6</b>	<b>2214.6</b>	<b>2597.7</b>	<b>2877.6</b>	<b>2829.2</b>	<b>2692.6</b>
Тэмээ	7.9	10.9	11.4	9.8	12.0	12.8	12.5	11.2
Адуу	81.9	120.5	132.4	128.5	112.1	129.1	123.1	107.9
Үхэр	152.9	180.6	156.4	157.3	195.1	187.0	175.7	160.0
Хонь	1093.1	1110.6	1108.7	1107.5	1410.4	1364.6	1265.8	1254.0
Ямаа	492.4	807.6	908.7	811.5	868.1	1184.1	1252.1	1159.5

Хэрэглээнд зарцуулсан малын 37.5 хувийг зах зээлд худалдан борлуулж, 45.7 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулжээ.

Бүсээр авч үзвэл, Баруун бүсэд оны эхний малынхаа 19.6 хувь, Хангайн бүсэд 17.8 хувь, Төвийн бүсэд 20.0 хувь, Зүүн бүсэд 22.5 хувь, Улаанбаатард 9.0 хувийг тус тус хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 30.7 хувь нь Баруун, 30.4 хувь нь Хангайн бүсэд, 22.5 хувь нь Төвийн бүсэд, 16.0 хувь нь Зүүн бүсэд, 0.4 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Малтай нэг өрх дунджаар 9.8 толгой малыг зах зээлд борлуулж, 12 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн судалгаа гарав.

**III.2.9. Сүргийн бүтэц.** 2006 оны байдлаар нийт сүргийн 33.1 хувь буюу 11504.1 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 23.7 хувь буюу 8248.5 мянган толгой нь нас гүйцсэн мал, 42.3 хувь буюу 14712.4 мянган толгой нь хээлтэгч мал, 1.0 хувь буюу 338.0 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

Хүснэгт 31

**2006 оны сүргийн бүтэц**

	Толгойгоор, мян.тол					Хувиар				
	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээлтэгч	Хээлтүүлэгч
<b>Бүгд</b>	<b>34802.9</b>	<b>11504.0</b>	<b>8248.2</b>	<b>14712.7</b>	<b>338.1</b>	<b>100.0</b>	<b>33.1</b>	<b>23.7</b>	<b>42.3</b>	<b>1.0</b>
Тэмээ	253.5	90.7	82.8	76.8	3.3	100.0	35.8	32.7	30.3	1.3
Адуу	2114.8	797.1	639.9	594.0	83.7	100.0	37.7	30.3	28.1	4.0
Үхэр	2167.9	1020.6	276.9	839.4	31.0	100.0	47.1	12.8	38.7	1.4
Хонь	14815.1	4956.9	3135.8	6611.5	110.8	100.0	33.5	21.2	44.6	0.7
Ямаа	15451.7	4638.8	4113.0	6590.7	109.2	100.0	30.0	26.6	42.7	0.7

2006 онд төл, өсвөр насны малын сүрэгт эзлэх хувь 0.4 пунктээр нэмэгдэж, харин нас гүйцсэн эр мал, хээлтэгчийн нийт сүрэгт эзлэх хувь 0.1-0.2 пунктээр буурч, хээлтүүлэгчийнх өнгөрсөн оны түвшинд байна.

## Сүргийн бүтэц, хувиар

	Төл, өсвөр насны				Нас гүйцсэн эр			
	2003	2004	2005	2006	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>32.9</b>	<b>34.8</b>	<b>32.7</b>	<b>33.1</b>	<b>23.5</b>	<b>22.7</b>	<b>23.9</b>	<b>23.7</b>
Тэмээ	27.6	32	35.2	35.8	40.7	36.4	33.5	32.7
Адуу	31.1	34.3	36.7	37.7	34.9	32.9	31.1	30.3
Үхэр	44.8	46.1	47.1	47.1	13.5	12.7	12.5	12.8
Хонь	33.8	35.2	33.5	33.5	20.2	19.9	21.1	21.2
Ямаа	30.4	32.8	29.2	30.0	25.9	25	26.9	26.6
үргэлжлэл								
	Хээлтэгч				Хээлтүүлэгч			
	2003	2004	2005	2006	2003	2004	2005	2006
<b>Бүгд</b>	<b>42.5</b>	<b>41.4</b>	<b>42.4</b>	<b>42.3</b>	<b>1.2</b>	<b>1.1</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>
Тэмээ	30.3	30.2	30	30.3	1.5	1.4	1.3	1.3
Адуу	29.5	28.5	28.1	28.1	4.5	4.3	4.1	4.0
Үхэр	40.2	39.8	38.9	38.7	1.5	1.4	1.4	1.4
Хонь	45.1	44	44.6	44.6	0.8	0.8	0.8	0.7
Ямаа	42.9	41.5	43.1	42.7	0.8	0.7	0.7	0.7

## VI. Эрчимжсэн мал аж ахуй

**VI.1. Цэвэр үүлдэр болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.** 2006 оны эцэст цэвэр үүлдрийн 1783.0 мянган мал, эрлийз 505.0 мянга, сайжруулсан нутгийн үүлдрийн 1487.5 мянган мал, нутгийн шилмэл омгийн 774.3 мянган мал тоологдов.

2005 онтой харьцуулахад цэвэр үүлдрийн мал 17.2 хувиар буюу 262.3 мянган толгойгоор, эрлийз мал 41.5 хувь буюу 148.1 мянган толгойгоор, нутгийн шилдэг омгийн мал 11.0 хувь буюу 76.9 мянган толгойгоор, сайжруулсан нутгийн үүлдрийн мал 16.2 хувь буюу 207.5 мянган толгойгоор тус тус өслөө.

Хүснэгт 33

### Цэвэр болон эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо

МЯН.ТОЛ

	2002	2003	2004	2005	2006	2006/2005	
						%	зөрүү
<b>Цэвэр үүлдрийн</b>	<b>645.9</b>	<b>1161</b>	<b>1211.3</b>	<b>1520.7</b>	<b>1783.0</b>	<b>117.2</b>	<b>262.3</b>
Үхэр	25.3	15.7	26.5	21.7	30.2	139.2	8.5
Хонь	504.2	975.3	1013.1	1205.2	1411	117.1	205.8
Ямаа	116.4	170	171.7	293.8	341.8	116.3	48.0
<b>Эрлийз мал</b>	<b>937.5</b>	<b>380.4</b>	<b>450.4</b>	<b>356.9</b>	<b>505.0</b>	<b>141.5</b>	<b>148.1</b>
Үхэр	91.6	57.9	53.5	55.5	62.3	112.3	6.8
Хонь	545.5	68.1	73.7	53.9	57.7	107.1	3.8
Ямаа	300.4	254.4	323.2	247.5	385.0	155.6	137.5
<b>Нутгийн шилдэг омгийн</b>	<b>1152.4</b>	<b>572.8</b>	<b>708.4</b>	<b>697.4</b>	<b>774.3</b>	<b>111.0</b>	<b>76.9</b>
Үхэр	3.8	2.5	0.7	0.5	2.1	420.0	1.6
Хонь	564.7	65.5	81.6	113	103.9	91.9	-9.1
Ямаа	542.4	480.6	599.4	560.1	634.3	113.2	74.2
Тэмээ	5.2	5.2	5.3	7.3	8.7	119.2	1.4
Адуу	36.3	19	21.4	16.5	25.3	153.3	8.8
<b>Сайжруулсан нутгийн үүлдрийн</b>	<b>-</b>	<b>1111.5</b>	<b>1177.5</b>	<b>1280</b>	<b>1487.5</b>	<b>116.2</b>	<b>207.5</b>
Тэмээ	-	0.5	0.7	1.3	0.5	38.5	-0.8
Адуу	-	10.2	12.6	21.3	10.2	47.9	-11.1
Үхэр	-	21.8	23.2	27.9	19.8	71.0	-8.1
Хонь	-	738.8	719	753.3	892.7	118.5	139.4
Ямаа	-	340.2	422	449.6	564.3	125.5	114.7

Нийт малын 5.1 хувийг цэвэр үүлдрийн мал, 1.5 хувийг эрлийз үүлдрийн мал, 2.2 хувийг нутгийн шилдэг омгийн мал, 4.3 хувийг сайжруулсан нутгийн үүлдрийн мал тус тус эзэлж байна (Хавсралт 35, 36)

**VI.1. Эрчимжсэн аж ахуйн талаар.** Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 2

жилд эрчимжсэн фермерийн аж ахуй тоо нилээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна.

Хүснэгт 34

### Эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо

	Бүгд		Сүүний үхрийн		Махны үхрийн		Мах, ноосны хонь		Гахай		Тахиа		Зөгий	
	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006
Фермерийн тоо	284	599	186	395	11	7	12	13	21	72	38	81	16	31

2006 оны байдлаар улсын хэмжээнд 599 эрчимжсэн аж ахуй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад фермерийн аж ахуйн тоо 315-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 35

### Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа фермерт өсгөн үржүүлж байгаа малын тоо

	Сүүний үхэр			Махны үхэр			Мах, ноосны хонь		
	фермерийн тоо	үхрийн тоо	1 аж ахуйд ногдох мал	фермерийн тоо	үхрийн тоо	1 аж ахуйд ногдох мал	фермерийн тоо	малын тоо	1 аж ахуйд ногдох мал
<b>ДҮН</b>	<b>395</b>	<b>8012</b>	<b>20</b>	<b>7</b>	<b>1334</b>	<b>191</b>	<b>13</b>	<b>6750</b>	<b>519</b>

үргэлжлэл

	Гахай			Тахиа			Зөгий		
	фермерийн тоо	Гахайны тоо	1 аж ахуйд ногдох гахай	фермерийн тоо	тахианы тоо	1 аж ахуйд ногдох тахиа	фермерийн тоо	Зөгийн тоо, бүл	1 аж ахуйд ногдох зөгий, бүл
<b>ДҮН</b>	<b>72</b>	<b>8948</b>	<b>124</b>	<b>81</b>	<b>390173</b>	<b>2350</b>	<b>31</b>	<b>1221</b>	<b>39</b>

2006 онд сүүний чиглэлийн нэг фермерийн аж ахуйд 20 толгой үхэр, махны чиглэлийн нэг фермерийн аж ахуйд 191 толгой үхэр, мах, ноосны чиглэлийн 1 фермерийн аж ахуйд 519 толгой хонь, гахайн нэг фермерийн аж ахуйд 124 гахай, тахианы нэг фермерийн аж ахуйд 2350 тахиа, зөгийний нэг фермерийн аж ахуйд 39 ам бүл зөгий ногдож байна.

Эдгээр эрчимжсэн фермерийн аж ахуй нь жилд нэг үнээнээс 1220-2250 кг сүү, нэг өндөглөгчөөс 150-290 ширхэг өндөг, нэг бүл зөгийнөөс 6.5-25.0 кг бал, нэг хониноос 2.8-3.6 кг нарийн нарийвтар ноос ашиглаж байна.



## V. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

**V.1. Бэлчээрийн хүрэлцээ.** Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын 2006 оны газрын нэгдмэл сангийн урьдчилсан тайлангаар манай улсын бэлчээр хадлангийн талбай 113.3 сая га талбайд хүрч 2005 оныхтой ижил түвшинд байна.

Хүснэгт 36


**Бэлчээрийн хүрэлцээ хангамж**

	2002	2003	2004	2005	2006
Хадлан бэлчээрийн талбай, сая.га	128.9	113.1	112.8	113.3	113.3
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	35	41	44	46	51

2006 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 51 толгой мал ногдож байна

Зураг 12

**100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо**



2006 онд 100 га талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо хүн амын шилжилт хөдөлгөөн харьцангуй их байгаа аймаг, хот болон малын тоогоор улсад тэргүүлдэг зарим аймагт өндөр байна. Увс, Ховд, Баян-Өлгий зэрэг алслагдсан аймгуудаас малчид төв суурин газрыг бараадан ирж, Орхон, Улаанбаатар, Дархан-Уул, Булган аймагт их хэмжээгээр суурших болсноос, 100 га хадлан бэлчээрийн талбайд Орхон аймагт 728 толгой, Улаанбаатарт 260 толгой, Дархан-Уул аймагт 166, Булган аймагт 117 толгой, мөн малын тоогоор улсад дээгүүрт ордог Архангай аймагт 134 толгой, Хөвсгөл аймагт 124 толгой тус тус ногдож байна. Бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 100 га хадлан бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 81 толгой мал ногдож энэ улсын дундаж болон бусад бүстэй харьцуулахад өндөр байна.

**V.2 Бэлчээр, ургамал хамгаалал.** Малын бэлчээрийн даац хэтрэхэд малын бэлчээрийн ургамлыг сүйтгэгч мэрэгч, хортон шавьжийн хөнөөл ихээхэн нөлөө үзүүлж

байна. Бэлчээр, ургамлыг хамгаалах ажлын хүрээнд ХХААЯ-наас 2006 нд нийт 8 аймгийн 50 сумын 306.0 мянган га бэлчээрийн талбайд огтонотой тэмцэх арга хэмжээг энгийн механик, биологийн болон микробиологийн аргыг хослуулан дунджаар 86.0 хувийн үр дүнтэй зохион байгуулснаас 276.0 мянга га буюу 90.0 хувийг энгийн механик, биологийн аргаар, 30.0 мянган га буюу 10.0 хувийг микробиологийн аргаар тус тус гүйцэтгэсэн байна. Энэ арга хэмжээнд улсын төсвөөс нийт 379.4 сая төгрөг зарцуулсан бөгөөд 1 га газарт дунджаар 1239 төгрөг ногдож байна.

Мөн 2006 онд царцаатай тэмцэх ажлыг 2006 онд нийт 6 аймгийн 30 сумын 71.5 мянган га талбайд дунджаар 95.3 хувийн үр дүнтэй зохион байгуулсан бөгөөд 65.0 мянган га буюу 90.9 хувийг химийн аргаар, 5.0 мянган га буюу 6.9 хувийг биологийн аргаар, 1.5 мянган га буюу 2.2 хувийг энгийн аргаар гүйцэтгэсэн байна. Энэ ажилд 256.4 сая төгрөг зарцуулагдсан байна.

**V.3. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж.** 2006 онд улсын хэмжээгээр тэжээлийн нэгжид шилжүүлснээр 535.9 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь 2005 оныхоос 14.4 хувь буюу 67.4 мянган тонноор өсөв. Бэлтгэсэн тэжээлийг нэр төрлөөр авч үзвэл хадлан, эрдэс тэжээлийн хэмжээ 2005 оныхоос 3.9-138.2 мянган тонноор буюу 8.7-16.4 хувиар өсч, сүрэл, гар тэжээл, дарш бэлтгэл 2005 оныхоос 0.2-6.0 мянган тонноор буюу 3.4-60.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 37

### Бэлтгэсэн тэжээл, нэр төрлөөр

МЯН.ТН


	2002	2003	2004	2005	2006	<u>2006%</u> 2005
Байгалийн хадлан	767	840.6	850.5	845.1	983.3	116.4
Сүрэл	9.0	22.5	19.2	10.0	4.0	40.0
Гар тэжээл	26.9	30.5	30.4	35.2	34.0	96.6
Бэлтгэсэн дарш	1.8	3.8	2.1	0.9	0.7	77.8
Эрдэс тэжээл	32.3	42.6	39	44.6	48.5	108.7
Үйлдвэрлэсэн тэжээл- бүгд, (тэж.нэгж)	411.4	465	464.2	468.5	535.9	114.4

Тэжээл үйлдвэрлэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжид шилжүүлснээр/ Архангай, Орхон, Дорнод, Сүхбаатар аймагт 2005 оныхоос 15.7-877.5 тонноор буурч, бусад аймагт 545.9-12517.3 мянган тонноор өсөв. (Хавсралт 41-44).

Зураг 13

### Бэлтгэсэн хадлан

МЯН.ТОНН



Бүсээр авч үзвэл, тэжээл үйлдвэрлэлтийн хэмжээ /тэжээлийн нэгжээр / бүх бүсэд 2005 оныхоос 4.0-50.3 хувиар буюу 3.1-27.6 мянган тонноор нэмэгдсэн байна.

Нийт бэлтгэсэн тэжээлийн 22.9 хувь нь Баруун, 29.9 хувь нь Хангай, 28.8 хувь нь Төв, 15.1 хувь нь Зүүн, 3.4 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

Хүснэгт 38

#### Үйлдвэрлэсэн тэжээлийн хангамж

	2003	2004	2005	2006
Хонин толгойд шилжүүлсэн мал, мян.тол	46166.6	49070.4	52081.6	57800.0
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	10.1	9.5	9.0	9.3

2006 онд хонин толгойд шилжүүлсэн малын тоо 57.8 сая болж, 2005 оныхоос 11.0 хувиар буюу 5.7 сая толгойгоор өссөн байна. Хонин толгойд шилжүүлсэн нэг малд 9.3 кг тэжээл ногдож байгаа нь 2005 оныхоос 0.3 кг-аар илүү байна.

#### VI. Тэжээвэр амьтад

2006 онд 32.8 мянган гахай, 211.7 мянган шувуу, 859 цаа буга, 384 илжиг, 3404 бүл зөгий тоологдсон нь 2005 оныхоос гахай 10.1, шувуу 70.0 мянгаар, цаа буга 51, зөгий 2615 бүлээр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 39

#### Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо

	2002	2003	2004	2005	2006
Гахай (мян.тол)	13.3	13.7	17.2	22.7	32.8
Шувуу (мян.тол)	61.6	90.6	177.4	141.7	211.7
Цаа буга	652	612	634	808	859
Илжиг	307	320	402	386	384
Зөгий (бүл)	1177	1047	839	789	3404
Туулай	73	225	257	526	392
Гахайтай өрхийн тоо (мян.)	1.8	1.8	2	2.3	2.4
Шувуутай өрхийн тоо(мян.)	1.4	1.5	1.7	3.6	1.9

Тэжээвэр амьтдын дундаас гахай, шувууны аж ахуйг бусад аж ахуйгаас илүүтэйгээр эрхэлж байгаа бөгөөд 2006 онд 2.4 мянган өрх гахай, 1.9 мянган өрх шувуу өсгөн үржүүлж байна. Өсгөн үржүүлж байгаа гахайны 36.2 хувь нь Төвийн, 25.7 хувь нь Хангайн бүсэд, 32.6 хувь нь Улаанбаатард байна. Шувууны 73.8 хувь нь Улаанбаатар хотод, 18.1 хувь нь Төвийн бүсэд байгаа болно (Хавсралт 45-47).

2006 онд тэжээвэр амьтад өсгөн үржүүлдэг өрх 309.8 тонн гахайн мах бэлтгэж, 500.8 сая төгрөгийн борлуулалт, 76.3 тонн шувууны мах бэлтгэж, 86.2 сая төгрөгийн, 19.0 сая ширхэг өндөг бэлтгэж, 2078.9 сая төгрөгийн, 8.2 тонн зөгийн бал бэлтгэж, 90.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

## VII. Мал эмнэлэгийн үйлчилгээний талаархи мэдээлэл.

**VII.1. Мал эмнэлэгийн үйлчилгээ.** 2006 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 21.5 сая толгой мал хамрагдаж, нэг малд 88 төгрөгийн зардал, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 15.8 сая толгой мал хамрагдаж, нэг малд 12 төг, лабораторийн оношлогоо, шинжилгээнд 606.3 мянган толгой мал хамрагдаж, нэг малд 215 төгрөг, гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтад давхардсан тоогоор 5.9 сая толгой мал хамрагдаж, нэг малд 214 төг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 40

### Мал эмнэлэгийн арга хэмжээний мэдээ

	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ			Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ		
	Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо, мян.тол	Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд үарцжлгсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг	Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо, мян.тол	Паразиттах өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг
Дүн	21501.4	1898.0	88	15764.6	185.0	12

үргэлжлэл

	Лабораторийн оношлогоо, шинжилгээ			Гоц халдварт өвчний вакцинжуулалтын зардал		
	Лабораторийн шинжилгээнд хамрагдсан малын тоо, мян.тол	Лабораторийн шинжилгээнд зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг	Вакцинжуулалтад хамрагдсан малын тоо, мян.тол	Вакцинжуулалтад зарцуулсан зардал, сая.төг	1 малд ногдох зардал, төг
Дүн	606.3	130.4	215	5921.2	1266.2	214

## VIII. Малжуулалтын талаарх мэдээлэл

**VIII.1 Малжуулалт.** Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээг авч, нилээдгүй хөрөнгө, мөнгийг зарцуулж байна. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна.

**Малжуулалтад хамрагдсан өрхийн тоо, ам бүл**

	Малжуулалтанд хамрагдсан				1 өрхийн ам бүлийн тоо	
	Өрхийн тоо		Ам бүлийн тоо		2005	2006
	2005	2006	2005	2006		
<b>ДҮН</b>	<b>3811</b>	<b>4513</b>	<b>15738</b>	<b>19275</b>	<b>4.1</b>	<b>4.3</b>

2006 оны байдлаар улсын хэмжээнд 4511 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4.3 байна.

Малжуулалтад хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 702 өрхөөр буюу 18.4 хувиар нэмэгдсэн байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн 28.7 хувь нь Баруун, 16.7 хувь нь Хангайн, 37.5 хувь нь Төвийн, 15.8 хувь нь Зүүн, 1.4 хувь нь Улаанбаатарт ногдож байна.

**Малжуулалтаар олгогдсон малын тоо**

	Малжуулалтаар авсан малын тоо, тол		Үүнээс:				Малжуулалтаар авсан малд эзлэх хувь		Малжуулалтад хамрагдсан 1 өрхөд ногдох малын тоо	
			Бод малын тоо		Бог малын тоо		Бод мал	Бог мал		
	2005	2006	2005	2006	2005	2006			2005	2006
<b>ДҮН</b>	<b>114300</b>	<b>125923</b>	<b>6505</b>	<b>5427</b>	<b>107 795</b>	<b>120496</b>	<b>4.3</b>	<b>95.7</b>	<b>30</b>	<b>28</b>

Малжуулах арга хэмжээгээр дээрх өрхүүдэд нийт 125923 толгой мал олгогдсон бөгөөд олгосон малын 95.7 хувь нь бог мал, 4.3 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 28 толгой мал ногдож байна.

Малжуулалтад 2006 онд нийт 3212.3 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүний 24.8 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 6.3 хувь нь орон нутгийн хөрөнгөөр, 68.9 хувь нь бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна

**Малжуулалтад зарцуулсан хөрөнгийн тайлан**

	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая.төг		Үүнээс:			Нийт зарцуулсан хөрөнгөд эзлэх хувь		
			Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө мян.төг	Орон нутгийн хөрөнгө мян.төг	Бусад мян.төг	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Орон нутгийн хөрөнгө	Бусад
	2005	2006						
<b>ДҮН</b>	<b>2 803.0</b>	<b>3 213.3</b>	<b>797.9</b>	<b>202.7</b>	<b>2 212.7</b>	<b>24.8</b>	<b>6.3</b>	<b>68.9</b>

## IX. Худаг, усангийн тоо, усжуулалтын талаарх мэдээлэл

**IX.1 Худаг усан сан.** ҮСГ-аас хашаа, худаг уст цэгийн тооллогыг 3 жил тутамд мал тооллоготой хамтруулан явуулж байна. 2006 оны мал тооллоготой хамтруулан худаг, усан сангийн тооллогыг явуулж үр дүнг нэгтгэн гаргалаа.

2006 онд нийт 38.7 мянган ширхэг худаг, 0.8 мянган ширхэг усан сан тоологдлоо. Тоологдсон худгийн 10.1 мянга нь инженерийн хийцтэй, 28.6 мянга нь энгийн худаг байна. Нийт худгаас 24.8 мянга нь буюу 64.1 хувь нь малын бэлчээрт байршиж байна.

Хүснэгт 44

### Худаг, усан сангийн тоо

	х/н	1996	2000	2003*	2006
<b>Худаг -бүгд</b>	<b>мян.ш</b>	<b>34.4</b>	<b>30.9</b>	<b>40.9</b>	<b>38.7</b>
үүнээс:					
Инженерийн	мян.ш	13.0	8.2	19.5	10.1
Энгийн	мян.ш	21.4	22.7	21.4	28.6
Бэлчээрт байршдаг	мян.ш	27.6	21.7	32.3	24.8
Ашиглагддаггүй	мян.ш	6.3	5.8	12.8	4.8
<b>Усан сан</b>	<b>мян.ш</b>	<b>1.7</b>	<b>1.0</b>	<b>1.6</b>	<b>0.8</b>
Багтаамж	мян.м3	20.1	14.9	115	71.8

2003 онд ХХААЯ-наас худаг, усан сангийн тооллого үзлэг, тооллогын явуулсан бөгөөд 2003 оны худаг, сангийн тооллогын дүнг ХХААЯ-наас гаргасан дүнгээр авсан болно. 2006 онд тоологдсон нийт худгийн тоо 2003 оныхоос 2.2 мянга буюу 5.4 хувиар буурсан дүнтэй байна. Аймаг, бүсээрхи дэлгэрэнгүй мэдээллийг /хавсралт 47, 48/-аас үзнэ үү.

**IX.2 Усжуулалт.** Монгол Улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

2005 оноос эхлэн мал тооллоготой хамтруулан усжуулалтын мэдээллийг сум, аймаг, улсын дүнгээр цуглуулан авч нэгтгэн гаргаж байна.

2006 онд 1516 худаг шинээр ашиглалтанд орсноос 1171 нь энгийн уурхайн, 345 нь инженерийн хийцтэй худаг байна.

Хүснэгт 45

### 2006 онд шинээр гаргасан худгийн тайлан

	Шинээр гаргасан худгийн тоо, бүгд		Үүнээс:				Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая. төг		Үүнээс:		
			Инженерийн		энгийн уурхайн				Улсын төсвийн хөрөнгөөр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
			2005	2006	2005	2006					
<b>Дүн</b>	<b>1492</b>	<b>1516</b>	<b>183</b>	<b>345</b>	<b>1309</b>	<b>1171</b>	<b>1279.6</b>	<b>2674.0</b>	<b>1060.1</b>	<b>1071.4</b>	<b>542.5</b>

Шинээр худаг гаргахад нийт 2674.0 сая төгрөг зарцуулсны 39.6 хувь нь улсын төсвийн хөрөнгө, 40.1 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 20.3 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

Хүснэгт 46

### 2006 онд засварласан худгийн тайлан

	Засвар-ласан худгийн тоо, бүгд		Үүнээс:				Худаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая.төг				
			инженерийн хийцтэй		энгийн уурхайн						
	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006	Улсын төсвийн хөрөнгөөр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
<b>ДҮН</b>	<b>2341</b>	<b>2142</b>	<b>772</b>	<b>933</b>	<b>1569</b>	<b>1209</b>	<b>1713.3</b>	<b>2542.3</b>	<b>1144.3</b>	<b>1150.4</b>	<b>247.6</b>

2006 онд нийт 2142 худаг засварласнаас 1209 нь энгийн уурхайн, 929 нь инженерийн хийцтэй бөгөөд худгийн засвар шинэчлэлд нийт 2542.3 сая төгрөг зарцуулсан байна. Нийт зарцуулсан хөрөнгийн 45.0 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 45.2 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр, 9.7 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.


### Х. Хашааны тооллого

**Х.1 Хашааны тоо.** 2006 оны хашааны тооллогоор 37.2 сая толгой малын багтаамж бүхий 129.5 мянган ширхэг хашаа тоологдсон байна. Нийт тоологдсон хашааны 13.3 хувь нь буюу 17.2 мянга нь 3.6 сая толгой малын багтаамжтай дулаан байр, 61.3 хувь буюу 79.3 мянга нь 21.5 сая толгой малын багтаамжтай саравчтай хашаа, 25.5 хувь буюу 33.0 мянга нь 12.1 сая толгой малын багтаамжтай хашаа тус тус байна.

Нийт хашааны 23.4 хувь буюу 30.9 мянга нь 3.4 сая толгой багтаамжтай бод малын хашаа байна.

Зураг 14

Малын хашааны тоо, мян.ш



**Малын хашааны тоо**

	х/н	1996	2000	2003	2006
Хашаа-бүгд	мян.ш	101.4	113.5	121.2	129.5
Багтаамж	сая.тол	27.6	36.8	29.0	37.2
Дулаан байр	мян.ш	10.9	11.4	14.6	17.2
Багтаамж	сая.тол	2.3	1.8	2.1	3.6
Саравчтай хашаа	мян.ш	69.2	71.2	73.5	79.3
Багтаамж	сая.тол	17.4	19.5	17.0	21.5
Саравчгүй хашаа	мян.ш	21.3	30.9	33.1	33.0
Багтаамж	сая.тол	7.8	15.4	9.8	12.1
Нийт хашаанаас					
бодын	мян.ш	22	23.9	27.9	30.9
Багтаамж	сая.тол	2.2	2.8	2.5	3.4

Хашааны тоо 2003 оныхоос 8.2 мянга буюу 6.8 хувиар нэмэгдсэн байна. 2006 онд бүх төрлийн хашааны тоо 2003 онтой харьцуулахад өссөн байна.



## ДҮГНЭЛТ

Малын тоо, толгой 2006 онд 34.8 сая толгойд хүрч, 2005 оныхоос 4.4 саяар буюу 14.8 хувиар өслөө. Малын тоо толгой өсөхөд байгаль, цаг уур тааламжтай байж, бойжуулсан төлийн тоо 2005 оныхоос 1445.6 мянган толгойгоор нэмэгдсэн, зүй бус хорогдол 200.8 мянган толгойгоор буурсан нь голлон нөлөөлжээ.

Малын тоо толгойн өсөлт нь бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 49.6 хувийг ямаа, 43.8 хувийг хонь, 4.6 хувийг үхэр, 1.9 хувийг адуу хангасан байна.

Малын тоо, толгой өссөнөөр мал аж ахуйн салбарт ахиц гарч, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь 2006 онд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 89.3 хувийг эзэлж, оны үнээр 530.9 тэрбум, зэрэгцүүлэх үнээр 280.7 тэрбум төгрөгт хүрч, 2005 онтой харьцуулахад оны үнээр 10.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 8.2 хувиар тус тус өслөө.

Мал аж ахуйн салбарт 2006 онд 355.0 мянган тонн мах, 479.4 мянган тонн сүү, 15.2 мянган тонн ноос, 4.0 мянган тонн ноолуур, 6.5 сая ширхэг арьс шир үйлдвэрлэлээ.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад сүү 53.5 мянган тонн, ноос 1.1 мянган тонн, ноолуур 0.3 мянган тонноор тус тус нэмэгдэж, мах 31.5 мянган тонн, арьс шир 0.4 сая ширхэгээр буурсан байна.

2006 онд аминдаа малтай 225.4 мянган өрх байгаагийн 170.8 мянга нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 364.4 мянган малчид ажиллаж байна.

Малтай өрхөд нэг өрхөд 152 толгой, малчин нэг өрхөд 204 толгой мал тус тус ногдож, малтай нэг өрхөд ногдох малын тоо 20, малчин нэг өрхөд ногдох малын тоо 23 толгойгоор нэмэгдэв.

Мал аж ахуйн салбарын өсөлт нь хүн амын хүнсний хэрэглээнд нийлүүлж буй дотоодын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах боломжийг бүрдүүлэн, экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээг өсгөн, улмаар уг салбарын орлогын хэмжээг нэмэгдүүлэх таатай нөхцөл болж байна.

Малын тоо 2006 онд өмнөх оныхоос 4.4 сая толгойгоор өссөнөөр, 2007 онд мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн биет хэмжээг өсгөж, 370.0 орчим мянган тонн мах, 480.0 гаруй мянган тонн сүү, 4.7 мянган тонн ноолуур, 6.6 сая ширхэг арьс шир үйлдвэрлэх боломж харагдаж байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх нь шаардлагатай байна.

Ялангуяа мал аж ахуйн салбарт шинэчлэл хийж, ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал юм.

## **ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР**

## МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, бүс нутгаар

Аймаг	Малтай өрхийн тоо			Малчин өрхийн тоо			Нэг малчин өрхөд ногдох малын тоо		
	2004	2 005	2 006	2004	2005	2006	2004	2 005	2006
<b>ДҮН</b>	<b>229 437</b>	<b>225 393</b>	<b>225 366</b>	<b>169 024</b>	<b>168 344</b>	<b>170 755</b>	<b>166</b>	<b>181</b>	<b>204</b>
<b>БАРУУН БҮС</b>									
<b>ДҮН</b>	<b>66 396</b>	<b>65 389</b>	<b>65 880</b>	<b>48 829</b>	<b>48 781</b>	<b>49 343</b>	<b>175</b>	<b>189</b>	<b>221</b>
БӨ	16 467	15 499	15 194	11 511	10 961	11 078	117	120	133
ГО	10 106	10 159	10 411	8 083	8 129	8 375	190	226	263
ЗА	13 776	13 597	13 661	10 187	10 278	10 511	187	205	243
УВ	14 055	14 044	13 986	10 030	10 057	10 066	194	201	239
ХО	11 992	12 090	12 628	9 018	9 356	9 313	198	210	246
<b>ХАНГАЙН БҮС</b>									
<b>ДҮН</b>	<b>83 681</b>	<b>82 475</b>	<b>82 680</b>	<b>68 213</b>	<b>67 716</b>	<b>68 762</b>	<b>133</b>	<b>149</b>	<b>172</b>
АР	19 289	18 947	18 905	16 065	15 991	16 289	121	137	155
БХ	13 363	13 460	13 659	11 383	11 336	11 572	116	137	162
ӨВ	19 976	19 672	19 344	17 055	17 088	16 643	126	135	158
ХӨ	20 281	19 625	20 002	16 229	16 082	16 829	141	156	177
БУ	9 273	9 242	9 269	6 735	6 361	6 561	180	220	255
ОР	1 499	1 529	1 501	746	858	868	154	160	201
<b>ТӨВИЙН БҮС</b>									
<b>ДҮН</b>	<b>45 949</b>	<b>45 280</b>	<b>44 710</b>	<b>30 285</b>	<b>30 677</b>	<b>30 650</b>	<b>206</b>	<b>216</b>	<b>231</b>
ГС	854	865	863	500	505	571	259	309	298
ДО	5 300	5 020	4 358	3 936	3 858	3 490	259	252	204
ДУ	9 028	9 094	8 894	7 803	7 877	7 747	228	232	246
ӨМ	7 326	7 262	7 159	6 313	6 283	6 150	170	179	188
ДА	2 574	2 511	2 428	890	1 005	1 113	141	142	162
СЭ	7 810	7 608	7 662	2 893	3 169	3 110	200	198	249
ТӨ	13 057	12 920	13 346	7 950	7 980	8 469	195	223	257
<b>ЗҮҮН БҮС</b>									
<b>ДҮН</b>	<b>26 530</b>	<b>25 735</b>	<b>25 479</b>	<b>19 311</b>	<b>18 732</b>	<b>19 024</b>	<b>206</b>	<b>224</b>	<b>244</b>
ДД	7 314	6 972	6 893	4 628	4 350	4 563	192	225	244
СҮ	9 921	9 737	9 514	7 758	7 310	7 353	204	208	222
ХЭ	9 295	9 026	9 072	6 925	7 072	7 108	217	239	267
<b>УЛААНБААТАР</b>									
<b>УБ</b>	<b>6 881</b>	<b>6 514</b>	<b>6 617</b>	<b>2 386</b>	<b>2 438</b>	<b>2 976</b>	<b>95</b>	<b>101</b>	<b>108</b>

## МАЛЧДЫН ТОО, бүс нутгаар

Аймаг	Малчдын тоо			үүнээс			Нийт малчдаас эмэгтэй
	2004	2 005	2 006	16-34 настай	35-59 эр, 35-54 эм настай	60, 55-аас дээш насны	
<b>ДҮН</b>	<b>369 704</b>	<b>364 293</b>	<b>364 350</b>	<b>180 545</b>	<b>137 948</b>	<b>45 857</b>	<b>160 580</b>
<b>БАРУУН БҮС</b>							
<b>ДҮН</b>	<b>110 190</b>	<b>107 980</b>	<b>108 815</b>	<b>56 577</b>	<b>40 145</b>	<b>12 093</b>	<b>49 723</b>
БӨ	24 889	23 234	23 071	13 241	8 548	1 282	10 559
ГО	18 050	18 642	19 113	9 514	7 217	2 382	9 022
ЗА	23 560	23 300	23 417	11 602	8 561	3 254	10 803
УВ	21 988	21 343	21 222	11 066	7 514	2 642	9 770
ХО	21 703	21 461	21 992	11 154	8 305	2 533	9 569
<b>ХАНГАЙН БҮС</b>							
<b>ДҮН</b>	<b>143 979</b>	<b>140 775</b>	<b>143 844</b>	<b>71 213</b>	<b>54 543</b>	<b>18 088</b>	<b>62 486</b>
АР	31 648	32 073	32 293	16 058	12 654	3 581	11 967
БХ	24 378	24 445	24 254	13 071	8 472	2 711	11 618
ӨВ	35 329	33 779	35 041	17 087	13 052	4 902	15 669
ХӨ	37 295	36 315	37 084	18 296	14 165	4 623	16 488
БУ	13 733	12 529	13 489	6 053	5 532	1 904	6 013
ОР	1 596	1 634	1 683	648	668	367	731
<b>ТӨВИЙН БҮС</b>							
<b>ДҮН</b>	<b>65 450</b>	<b>66 427</b>	<b>63 063</b>	<b>29 752</b>	<b>24 028</b>	<b>9 283</b>	<b>27 909</b>
ГС	989	1 043	1 228	609	480	139	348
ДО	8 555	8 498	7 330	3 536	2 690	1 104	3 320
ДУ	17 339	16 936	16 487	8 567	5 664	2 256	7 585
ӨМ	13 358	13 152	12 053	6 468	4 236	1 349	5 807
ДА	1 689	2 541	2 016	764	876	376	658
СЭ	6 422	6 707	7 023	2 484	3 376	1 163	2 714
ТӨ	17 098	17 550	16 926	7 324	6 706	2 896	7 477
<b>ЗҮҮН БҮС</b>							
<b>ДҮН</b>	<b>43 923</b>	<b>42 749</b>	<b>42 510</b>	<b>21 129</b>	<b>16 929</b>	<b>4 452</b>	<b>18 278</b>
ДД	9 724	9 894	9 793	4 900	3 950	943	3 556
СҮ	19 000	18 214	18 342	9 672	7 255	1 415	8 088
ХЭ	15 199	14 641	14 375	6 557	5 724	2 094	6 634
<b>УЛААНБААТАР</b>							
<b>УБ</b>	<b>6 162</b>	<b>6 362</b>	<b>6 118</b>	<b>1 874</b>	<b>2 303</b>	<b>1 941</b>	<b>2 184</b>

## МАЛЧДЫН СОЁЛ АХУЙН НӨХЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, бүс нутгаар

	Малчин өрхийн тоо	Сум, дүүргийн тоо	Баг, хорооны тоо	цахилгаан гэрэлтэй	Үүнээс			
					нарны	салхины	бага оврын цахилгаан үүсгүүр	бусад
<b>ДҮН</b>	<b>170 755</b>	<b>340</b>	<b>1 664</b>	<b>78 711</b>	<b>62 053</b>	<b>7 101</b>	<b>3 287</b>	<b>6 270</b>
<b>БАРУУН БҮС</b>								
<b>ДҮН</b>	<b>49 343</b>	<b>92</b>	<b>461</b>	<b>25 753</b>	<b>22 836</b>	<b>568</b>	<b>765</b>	<b>1 584</b>
БӨ	11 078	14	84	5 210	4 156	373	87	594
ГО	8 375	18	83	4 681	4 435	59	187	0
ЗА	10 511	24	113	5 685	5 003	56	100	526
УВ	10 066	19	90	4 672	4 342	37	224	69
ХО	9 313	17	91	5 505	4 900	43	167	395
<b>ХАНГАЙН БҮС</b>								
<b>ДҮН</b>	<b>68 762</b>	<b>100</b>	<b>514</b>	<b>27 568</b>	<b>23 267</b>	<b>2 080</b>	<b>1 059</b>	<b>1 162</b>
АР	16 289	19	99	5 328	4 678	369	34	247
БХ	11 572	20	100	5 215	4 861	114	232	8
ӨВ	16 643	19	103	6 958	5 704	837	241	176
ХӨ	16 829	24	121	6 459	5 269	616	388	186
БУ	6 561	16	72	2 784	2 351	139	146	148
ОР	868	2	19	824	404	5	18	397
<b>ТӨВИЙН БҮС</b>								
<b>ДҮН</b>	<b>30 650</b>	<b>95</b>	<b>359</b>	<b>14 888</b>	<b>9 732</b>	<b>2 559</b>	<b>1 153</b>	<b>1 444</b>
ГС	571	3	9	188	134	41	5	8
ДО	3 490	14	57	1 577	729	600	179	69
ДУ	7 747	15	64	4 005	3 206	480	218	101
ӨМ	6 150	15	53	3 712	2 178	930	339	265
ДА	1 113	4	24	764	263	11	29	461
СЭ	3 110	17	49	1 375	914	76	156	229
ТӨ	8 469	27	103	3 267	2 308	421	227	311
<b>ЗҮҮН БҮС</b>								
<b>ДҮН</b>	<b>19 024</b>	<b>44</b>	<b>209</b>	<b>8 664</b>	<b>5 986</b>	<b>1 808</b>	<b>92</b>	<b>778</b>
ДД	4 563	14	59	1 640	775	695	0	170
СҮ	7 353	13	67	4 317	3 384	771	92	70
ХЭ	7 108	17	83	2 707	1 827	342	0	538
<b>УЛААНБААТАР</b>								
<b>УБ</b>	<b>2 976</b>	<b>9</b>	<b>121</b>	<b>1 838</b>	<b>232</b>	<b>86</b>	<b>218</b>	<b>1 302</b>

## Хавсралт 3-ын үргэлжлэл

	телевизор той	авто машинтай		мотоцикльтэй		трактортой		хийсэн эсгий /м/	малын хашаатай өрх	худагтай өрх
		өрхийн тоо	машины тоо	өрхийн тоо	мотоцикл ийн тоо	өрхийн тоо	тракторын тоо			
<b>ДҮН</b>	<b>70 199</b>	<b>26 578</b>	<b>27 382</b>	<b>41 990</b>	<b>42 244</b>	<b>2 656</b>	<b>2 714</b>	<b>179 727</b>	<b>111 703</b>	<b>30 576</b>
<b>БАРУУН БҮС</b>										
<b>ДҮН</b>	<b>22 461</b>	<b>8 391</b>	<b>8 643</b>	<b>12 377</b>	<b>12 397</b>	<b>541</b>	<b>543</b>	<b>70 727</b>	<b>31 368</b>	<b>6 396</b>
БӨ	4 571	2 005	2 111	2 502	2 503	64	64	20 488	7 003	1 158
ГО	4 407	1859	1906	3295	3309	49	51	1 873	5 622	1 945
ЗА	4 288	1572	1603	2445	2448	162	162	13435	5 767	235
УВ	4 085	1314	1346	1983	1984	111	111	25311	6 315	1 004
ХО	5 110	1641	1677	2152	2153	155	155	9620	6 661	2 054
<b>ХАНГАЙН БҮС</b>										
<b>ДҮН</b>	<b>24 997</b>	<b>8 601</b>	<b>8 835</b>	<b>15 799</b>	<b>15 806</b>	<b>787</b>	<b>824</b>	<b>58 857</b>	<b>45 625</b>	<b>7 315</b>
АР	3 506	1393	1461	2526	2528	102	103	7253	12877	959
БХ	5 218	1840	1874	3585	3546	61	60	14262	5 082	2 118
ӨВ	6 143	1833	1871	4349	4374	45	46	30546	7 866	2 150
ХӨ	6 576	2022	2089	3773	3786	214	220	6220	13732	1052
БУ	2 913	1434	1460	1393	1399	345	375	516	5119	605
ОР	641	79	80	173	173	20	20	60	949	431
<b>ТӨВИЙН БҮС</b>										
<b>ДҮН</b>	<b>12 359</b>	<b>6 260</b>	<b>6 459</b>	<b>9 423</b>	<b>9 592</b>	<b>770</b>	<b>777</b>	<b>41 207</b>	<b>21 737</b>	<b>11 433</b>
ГС	275	101	110	232	235	9	9	0	315	174
ДО	1 292	619	653	1196	1208	21	21	519	2317	1749
ДУ	3 364	1698	1754	3290	3393	42	42	14257	4972	3143
ӨМ	2 906	1418	1454	2886	2925	41	42	17286.5	3800	4222
ДА	658	255	262	97	97	65	66	4864.3	990	471
СЭ	980	678	704	311	311	297	300	1 672	4 202	1 149
ТӨ	2 884	1 491	1 522	1 411	1 423	295	297	2 608	5 141	525
<b>ЗҮҮН БҮС</b>										
<b>ДҮН</b>	<b>8 318</b>	<b>2 820</b>	<b>2 921</b>	<b>4 166</b>	<b>4 223</b>	<b>483</b>	<b>486</b>	<b>7 406</b>	<b>10 724</b>	<b>5 294</b>
ДД	2 059	479	497	809	814	179	181	306	2 720	1 933
СҮ	3 548	1 031	1 045	2 152	2 173	52	53	4 826	3 142	2 309
ХЭ	2 711	1 310	1 379	1 205	1 236	252	252	2 274	4 862	1 052
<b>УЛААНБААТАР</b>										
<b>УБ</b>	<b>2 064</b>	<b>506</b>	<b>524</b>	<b>225</b>	<b>226</b>	<b>75</b>	<b>84</b>	<b>1 530</b>	<b>2 249</b>	<b>138</b>

малчин ерхийн тоонд харьцуулбал /хувиар/												
	цахилгаан гэрэлтэй		телевизортой		машинтай		мотоцикльтэй		трактортой		малын хашаатай өрх	худагтай өрх
	2 005	2 006	2 005	2 006	2 005	2 006	2 005	2 006	2 005	2 006		
<b>ДҮН</b>	<b>40.2</b>	<b>46.1</b>	<b>35.7</b>	<b>41.1</b>	<b>13.8</b>	<b>15.6</b>	<b>22.2</b>	<b>24.6</b>	<b>1.4</b>	<b>1.6</b>	<b>65.4</b>	<b>17.9</b>
<b>БАРУУН БҮС</b>												
<b>ДҮН</b>	<b>44.4</b>	<b>52.2</b>	<b>39.0</b>	<b>45.5</b>	<b>15.3</b>	<b>17.0</b>	<b>22.0</b>	<b>25.1</b>	<b>1.1</b>	<b>1.1</b>	<b>63.6</b>	<b>13.0</b>
БӨ	36.7	47.0	26.2	41.3	15.8	18.1	18.1	22.6	0.6	0.6	63.2	10.5
ГО	49.9	55.9	46.0	52.6	20.0	22.2	35.6	39.3	0.6	0.6	67.1	23.2
ЗА	43.8	54.1	41.7	40.8	15.3	15.0	23.8	23.3	1.6	1.5	54.9	2.2
УВ	37.8	46.4	33.6	40.6	11.4	13.1	16.8	19.7	1.3	1.1	62.7	10.0
ХО	56.6	59.1	50.7	54.9	14.8	17.6	18.1	23.1	1.4	1.7	71.5	22.1
<b>ХАНГАЙН БҮС</b>												
<b>ДҮН</b>	<b>33.8</b>	<b>40.1</b>	<b>30.9</b>	<b>36.4</b>	<b>10.7</b>	<b>12.5</b>	<b>20.2</b>	<b>23.0</b>	<b>1.0</b>	<b>1.1</b>	<b>66.4</b>	<b>10.6</b>
АР	32.7	32.7	21.5	21.5	8.6	8.6	15.5	15.5	0.6	0.6	79.1	5.9
БХ	42.9	45.1	41.5	45.1	14.5	15.9	28.0	31.0	0.5	0.5	43.9	18.3
ӨВ	36.3	41.8	33.1	36.9	9.1	11.0	25.4	26.1	0.4	0.3	47.3	12.9
ХӨ	27.6	38.4	32.2	39.1	11.4	12.0	17.4	22.4	1.3	1.3	81.6	6.3
БУ	37.4	42.4	31.6	44.4	16.5	21.9	19.3	21.2	4.3	5.3	78.0	9.2
ОР	62.5	94.9	56.2	73.8	6.2	9.1	18.5	19.9	1.4	2.3	109.3	49.7
<b>ТӨВИЙН БҮС</b>												
<b>ДҮН</b>	<b>44.6</b>	<b>48.6</b>	<b>36.1</b>	<b>40.3</b>	<b>19.1</b>	<b>20.4</b>	<b>29.2</b>	<b>30.7</b>	<b>2.2</b>	<b>2.5</b>	<b>70.9</b>	<b>37.3</b>
ГС	37.2	32.9	47.7	48.2	15.6	17.7	31.1	40.6	1.2	1.6	55.2	30.5
ДО	40.7	45.2	37.9	37.0	17.8	17.7	30.6	34.3	0.5	0.6	66.4	50.1
ДУ	48.8	51.7	35.7	43.4	19.9	21.9	42.7	42.5	0.6	0.5	64.2	40.6
ӨМ	55.7	60.4	38.9	47.3	21.4	23.1	43.1	46.9	0.5	0.7	61.8	68.7
ДА	64.2	68.6	46.4	59.1	25.5	22.9	9.7	8.7	6.7	5.8	88.9	42.3
СЭ	35.9	44.2	33.3	31.5	16.1	21.8	8.8	10.0	7.6	9.5	135.1	36.9
ТӨ	35.0	38.6	32.5	34.1	15.6	17.6	14.8	16.7	3.2	3.5	60.7	6.2
<b>ЗҮҮН БҮС</b>												
<b>ДҮН</b>	<b>40.9</b>	<b>45.5</b>	<b>38.9</b>	<b>43.7</b>	<b>12.6</b>	<b>14.8</b>	<b>20.7</b>	<b>21.9</b>	<b>2.3</b>	<b>2.5</b>	<b>56.4</b>	<b>27.8</b>
ДД	37.7	35.9	47.3	45.1	11.0	10.5	18.6	17.7	4.1	3.9	59.6	42.4
СҮ	55.7	58.7	44.8	48.3	11.0	14.0	27.9	29.3	0.9	0.7	42.7	31.4
ХЭ	27.6	38.1	27.6	38.1	15.2	18.4	14.6	17.0	2.6	3.5	68.4	14.8
<b>УЛААНБААТАР</b>												
<b>УБ</b>	<b>74.8</b>	<b>61.8</b>	<b>75.7</b>	<b>69.4</b>	<b>19.2</b>	<b>17.0</b>	<b>7.7</b>	<b>7.6</b>	<b>2.1</b>	<b>2.5</b>	<b>75.6</b>	<b>4.6</b>

## МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ , бүс нутгаар

	10 хүртэл малтай		11-30 хүртэл малтай		31-50 хүртэл малтай		51-100 хүртэл малтай		100 хүртэл малтай өрх-бүгд	
	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006	2005	2006
<b>ДҮН</b>	<b>24 280</b>	<b>21 710</b>	<b>32 215</b>	<b>27 791</b>	<b>26 919</b>	<b>24 175</b>	<b>46 139</b>	<b>43 687</b>	<b>129 553</b>	<b>117 363</b>
<b>БАРУУН БҮС</b>										
<b>ДҮН</b>	<b>4 910</b>	<b>4 449</b>	<b>8 198</b>	<b>6 362</b>	<b>7 602</b>	<b>6 679</b>	<b>14 213</b>	<b>13 428</b>	<b>34 923</b>	<b>30 918</b>
БӨ	1 862	1 703	2 824	1 934	2 247	2 059	3 996	4 012	10 929	9 708
ГО	217	160	882	679	961	812	2 036	1 823	4 096	3 474
